**МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН**
**2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Үйл ажиллагааны зардлаар , санхүүжилт эх үүсвэр | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хариуцах нэгж | Биелэлт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| НЭГ: ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ | | | | | | | | |
| Стратегийн зорилго 1: Монгол Улсын хууль, тогтоомж, бодлого, шийдвэрийг хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэхэд хувь нэмрээ оруулах | | | | | | | | |
| Зорилт 1.1 | | Монгол Улсын хүний эрх эрх чөлөөний үндэсний индексийг тодорхойлох, хууль тогтоомж, бодлого шийдвэрийн Төслийн зардлаар боловсруулахад хүний эрхийн нөлөөллийг тооцох аргачлалыг боловсронгуй болгох Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын индексийг боловсруулах | | | | | | |
| 1.1.1 | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлийг боловсруулах, өргөн барих, англи хэл рүү орчуулах, илтгэлийг хэвлүүлэх, сурталчлах, түгээх; | Үйл ажиллагааны зардлаар | Илтгэлийг хуульд заасан хугацаанд боловсруулан өргөн барьсан байх. | 1 | 2 | Тамгын газар | 1. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлийг "Ковид-19 цар тахлын хүний эрх, эрх чөлөөний сургамж", "Жендэрийн эрх тэгш байдал ба хүний эрх", “Хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал”, “Гэр бүлийн хүчирхийллээс ангид байх эрх”, "Цэргийн алба хаагч хоорондын дүрмийн бус харьцааны нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ", "Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээ" гэсэн 6 багц хүний эрхийн асуудлаар Комиссоос хийсэн хяналт шалгалт, ажиглалт, мониторинг, иргэдээс ирүүлсэн гомдол мэдээлэл, Комиссын гмшүүний шаардлага, зөвлөмж, цар тахлын үед Засгийн газар, Улсын онцгой комисс, яамд, агентлаг, холбогдох төрийн байгууллагуудын шийдвэр, үйл ажиллагааны хэрэгжилт, иргэний нийгэм, олон улсын байгууллага, судлаачдын хийсэн судалгаа, мэдээлэлд тулгуурлан боловсруулж 2022.04.14-ний өдөр Улсын Их Хуралд хүргүүлсэн.<br>ХЭҮК нь Ковид-19 цар тахал эхэлснээс хойш хоёр жил гаруй хугацаанд хүний эрх, эрх | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | чөлөөний хэрэгжилтэд үзүүлж буй сөрөг нөлөөллийг багасгах, нийгмийн тэгш бус байдлыг бууруулах, цаашид хохирол багатай даван туулахад анхаарвал зохих хүний эрхийн асуудлаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 9, 17 дугаар зүйлд тус тус заасныг үндэслэн УИХ-аар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулахаар 30 санал хүргүүлсэн. УИХ- ын Хууль зүйн байнгын хороо, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлийг 2022.06.16-ны өдөр хэлэлцсэн.<br>2. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах үйл ажиллагааны төлөвлөгөөг 2022.04.15-нд баталсан ба төлөвлөгөөний хэрэгжилт 80 хувьтай байна. Тайлант хугацаанд Комиссын гишүүд 21 дэх илтгэлийг олон нийтэд таниулах талаар МҮОНРТВ болон арилжааны телевизүүдийн “Мэдээллийн хөтөлбөр”, “Зочны цаг”, “Ярилцлагын нэвтрүүлэг”-т 30 гаруй удаа мэдээ, мэдээлэл өгч, Зууны мэдээ, Өдрийн сонин, Өнөөдөр, Өглөөний сонинуудад илтгэлд дурдсан хүний эрхийн тодорхой асуудлыг хөндсөн нийтлэл, сурвалжлаг, мэдээ мэдээлэл 28 удаа нийтлэгдсэн.<br>2022.04.22-ны өдөр илтгэлийн 6 бүлэг тус бүрээр иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийг оролцуулсан нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд үйл ажиллагаагаа сурталчилсан.<br>Илтгэлийг олон нийтэд хүргэх зорилгоор цахим хувийг Комиссын цахим хуудас болон Хүний эрхийн цахим номын санд байршуулахын зэрэгцээ хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч нарт хүргүүлсэн ба | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нийт 1000 хувь хэвлүүлсэн илтгэлийг 108 байгууллага, албан тушаалтанд 362 ширхгийг хүргүүлж, 350 ширхгийг албан хэрэгцээнд болон зочид төлөөлөгч нарт өгч 288 ширхэг үлдэгдэлтэй байна. Илтгэлийг англи хэл рүү орчуулах орчуулагтай гэрээ байгуулж, хийсэн орчуулгыг 04, 05, 06 дугаар сард бүлэг бүлгээр хэсэгчлэн хүлээн авч, хяналтад өгөхөд бэлэн болгосон. | |
| 1.1.2 | Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын индексийг боловсруулах ажлыг эхлүүлэх; | Төслийн зардлаар | Индекс боловсруулсан ажлыг эхлүүлсэн байна. | 0 | 100% | ХЭБСХ, ОУГЭЗХАХ ҮСХ ХЭДКГ | "Монгол Улсын хүний эрх эрх чөлөөний хэрэгжилтийг тодорхойлох индекс боловсруулах ажлын удирдамж"-ийг баталж, гүйцэтгэгчийг шалгаруулж, гэрээ байгуулж ажлыг эхлүүлсэн.<br>Шинэ Зеланд Улсад төвтэй "Хүний эрхийг хэмжих санаачлага" байгууллагатай хамтран ажиллах, боломжийн талаар санал солилцох цахим уулзалт хийсэн. | 100% |
| 1.1.3 | УИХ-д өргөн барьсан хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн төслийг Хууль тогтоомжийн тухай хууль, 2016 оны Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалуудад хүний эрхийн үүднээс саналын төсөл боловсруулж, хүргүүлэх;<br><br>Хэрэгцээ шаардлагын судалгаа хийх | Төслийн зардлаар | Санал хүргүүлсэн байна.<br><br>Хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах үе шат | 0 | 1 | Тамгын газар<br><br>Дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа эсэх нь тодорхойгүй | Тайлант хугацаанд Байгальд зорчих, аялах эрхийн тухай хуулийн төсөл, 8 эрх зүйн актын төсөлд нийт 35 санал өгсөн. Үүнд:<br>**Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд**<br>- "Туслах малчны хөдөлмөрийн гэрээний загвар"-ын төсөлд 9 санал;<br>- "Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт", "13 нас хүрсэн хүний эрхэлж болох хөнгөн ажлын төрөл, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл"-д 7 санал;<br>**Үндэсний статистикийн хороонд**<br>- Ажиллах хүчний болон албадан хөдөлмөрийн судалгааны санал асуулгын маягтад 5 санал;<br>**Хууль зүй, дотоод хэргийн яаманд**<br>- "Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн ажиллах журам", "Хязгаарлалттай мэдээллийг өгсөн, дамжуулсан тохиолдолд мэдээллийн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эзний мэдэгдэл хүргүүлэх, ашиглах хүсэлт гаргасан, гуравдагч этгээдэд өгсөн, дамжуулсан талаарх бүртгэл хөтлөх журам"-ын төсөлд 5 санал;<br>- Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжийн төсөлд 3 санал;<br>- "Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл, журам"-ын төсөлд 6 саналыг тус тус хүргүүлсэн.<br>ХЭҮК-ын дарга, гишүүн Ж.Хунангийн 2021.01.13-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэлийн эрх чөлөө, мэдэх эрхтэй холбоотой Хүний эрхийн Үндэсний Комиссын саналыг боловсруулах Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийг ХЭҮК-ын гишүүн Г.Нарантуяа ахалж, ажлын хэсгийн гишүүдэд Монголын хуульчдын холбооны гишүүн, хуульчид, Монголын Криминологчдын холбоо, МУИС, Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн сэтгүүл зүйн тэнхимийн эрдэмтэн доктор, багш нар ажиллаж байна.<br>Тус ажлын хэсэг хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой зохицуулалтыг сайжруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөний баталгааны тухай хуулийн төсөл, түүнийг дагалдах хуулийн төслүүдийн хамт боловсруулах ажлыг хийн, шийдвэр гаргагчид, оролцогч талуудад танилцуулахаар бэлтгэж байна. | |
| 1.1.4 | "Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал"-д хүний эрхийн үүднээс | Үйл ажиллагааны зардлаар | Аргачлалд санал өгсөн байна. | 0 | 1 | ХЭБСХ | Хугацаа болоогүй.<br><br>Мөн буруу төлөвлөлт. /1-4 улирал/ Эхний хагас жилд хүрэх түвшин, сүүлийн хагас жилд хүрэх түвшин гэж төлөвлөгөөндөө оруулаагүй. 1-4 улиралд. Эхний 1,2 дугаар улиралд | 0% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | саналын төсөл боловсруулж, ХЗДХЯ-д хүргүүлэх; | | | | | | хийгдээгүй бол сүүлийн улиралд хийнэ гэсэн төлөвлөлт | |
| **Зорилт 1.2** | | **Хүний эрхийг хангах, хамгаалах төрийн бодлого, хууль эрх зүйн орчныг сайжруулахад хувь нэмэр оруулах** | | | | | | |
| 1.2.1 | Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн хүрээнд тодорхойлсон болон хүний эрхийг хангах, хамгаалахад ач холбогдолтой дараах хууль тогтоомжийн төсөл боловсруулахад санал өгөх;<br>• Тайван жагсаал цуглаан хийх эвлэлдэн нэгдэх;<br>• Боловсролын багц хууль<br>• Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын тухай;<br>• Эрүүгийн багц хууль тогтоомжийн холбогдох хэсэгт. | Үйл ажиллагааны зардлаар | Хууль боловсруулахад Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөрт нийцүүлэн санал өгсөн байна.<br><br>Холбогдох байгууллагын шийдвэр гарсан эсэх тодорхойгүй, гол үр дүн байхгүй, | 27 | 32 | ХЭБСХ | Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн хүрээнд тодорхойлсон болон хүний эрхийг хангах, хамгаалахад ач холбогдолтой 3 хуулийн төсөлд 41 санал өгсөн. Үүнд:<br>- Боловсролын багц хуулийн төсөлд тусгуулах 20 санал боловсруулж Комиссын 2022.04.15-ны 02/367 дугаар албан бичгээр БСШУС-ын Байнгын хороонд.<br>- Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Комиссын 2022.04.12-ны өдрийн 02/357 дугаар албан бичгээр 21 саналыг тус тус хүргүүлсэн.<br>- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомжид санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж санал боловсруулах ажлыг эхлүүлсэн. | 100% |
| 1.2.2 | Хүний эрх, эрх чөлөөний асуудлаар дүн, шинжилгээ хийж Комиссын санал, зөвлөмж хүргүүлэх; | Үйл ажиллагааны зардлаар | Хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан санал, зөвлөмжийн тоо | 24 | 30 | ХЭБСХ | Тайлант хугацаанд ХЭҮК-оос нийт 13 заалт бүхий 2 зөвлөмж боловсруулж холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн. Үүнд:<br>- 2022.04.07, 08-ны өдрүүдэд зохион байгуулсан "Монголдоо тайван сайхан амьдаръя" жагсаал цуглааны үеэр иргэдэд хүч хэрэглэсэн асуудлаар 9 заалт бүхий 1 зөвлөмж;<br>- Боловсролын салбарын хэмжээнд суралцагчдын эрүүл, аюулгүй орчинд | 30% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сурч боловсрох эрхийг хангах, тэдний амь нас, эрүүл мэндийг аливаа эрсдэлт нөхцөл байдлаас хамгаалах асуудлаар 4 заалт бүхий 1 зөвлөмж.<br>Комиссын гишүүний 2 зөвлөмжийг дараах асуудлаар гаргаж холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлсэн. Үүнд:<br>- “Өлсгөлөнгийн үед эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тухай заавар”-ыг боловсронгуй болгох шаардлагатай тухай Комиссын гишүүний зөвлөмжийг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдад 2022.02.28-ны өдрийн 06/05 дугаар албан бичгээр;<br>- “Химийн хаягдлын эрсдэлийг бууруулах үндэсний холбоо” ТББ-аас “Аймаг, орон нутгийн ерөнхий боловсролын сургууль, их дээд сургууль болон эрдэм шинжилгээний байгууллагын сургалт, судалгааны ажилд хэрэглэгдэж байгаа химийн бодисын хэрэглээ, нэр төрөл тоо хэмжээ нэмэгдэж, хог хаягдлыг устгах үйл ажиллагаа хяналтгүй байгаа тухай ирүүлсэн мэдээллийн мөрөөр дүн шинжилгээ хийж боловсролын салбарын хэмжээнд суралцагчдын эрүүл, аюулгүй орчинд сурч боловсрох эрхийг хангах, тэдний амь нас, эрүүл мэндийг аливаа эрсдэлт нөхцөл байдлаас хамгаалах асуудлаар Комиссын гишүүний 2022.05.03-ны 01/02 дугаар зөвлөмжийг БШУЯ-нд тус тус хүргүүлсэн. | |
| 1.2.3 | Хүүхэд хамгааллын тогтолцооны үр нөлөө, мэргэжлийн байдлыг хангуулахад дэмжлэг үзүүлэх;<br>- Процессын явцад хүүхдийн эрхийн зөрчлийг | Үйл ажиллагааны зардлаар | Санал зөвлөмжийг хүргүүлж ажилласан байна. | 0 | 100% | ХЭБСХ, ГХШХ | 1. Процессын явцад хүүхдийн эрхийн зөрчлийг тодорхойлж, зөрчлийг арилгах саналыг холбогдох байгууллагад хүргүүлэх зорилгоор ХЭҮК, Монголын хуульчдын холбоо, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагатай хамтран 2022.05.26-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнд “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхдийн эрхийн асуудал | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тодорхойлж, зөрчлийг арилгах саналыг холбогдох байгууллагад хүргүүлэх<br><br>Өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, холбогдох байгууллагад хүргүүлсэн буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол гэдэг шаардлагад хамаарч байна гэж үзэн 70 оноо | | | | | | хэлэлцүүлэг"-ийг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын Хуульчдын холбоо, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шинжилгээ, өмгөөлөл зэрэг төрийн болон төрийн бус байгууллагын 93 хүн танхимаар, цахим хэлбэрээр 100 гаруй хүн оролцсон. Хэлэлцүүлгийн үеэр илтгэгч, панелист, оролцогчдоос гаргасан саналыг нэгтгэн холбогдох байгууллагуудад хүргүүлэх зөвлөмжийн төслийг боловсруулж Комиссын даргад танилцуулсан.<br>2. Аймгуудын Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх төлөвлөгөөний дагуу Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Сэлэнгэ, Сүхбаатар, Дундговь, Орхон, Баян-Өлгий, Завхан, Увс зэрэг 10 аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, 15 аймгийн 51 сургуулийн Дотуур байранд хяналт шалгалт хийж холбогдох албан тушаалтнуудад Комиссын гишүүний 3 зөвлөмж, 1 шаардлага хүргүүлсэн.<br>3. Комиссын гишүүний санаачилга, албан тушаалтны хүсэлтийн дагуу хүүхдийн эрхийн чиглэлээр дараах хяналт шалгалтыг зохион байгуулж, холбогдох албан тушаалтнуудад 2 шаардлага, 2 зөвлөмж өгсөн. Үүнд:<br>- Гандантэгчинлин хийдийн харьяа ерөнхий боловсролын 112 дугаар сургуульд шавилан суралцаж буй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтэд хийсэн шалгалтын мөрөөр Боловсрол шинжлэх ухааны сайдад шаардлага хүргүүлсэн.<br>- Унаач хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр 2 зөвлөмж, охидын үзлэг зохион байгуулахгүй байх тухай 1 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шаардлагыг холбогдох албан тушаалтнуудад тус тус хүргүүлж, Ховд аймаг дахь Хүүхэд хамгааллын бүтцэд хяналт шалгалт хийж, илтгэх хуудсыг Комиссын даргад танилцуулсан. | |
| **Зорилт 1.3** | | **Хүний эрхийн үндэсний хөтөлбөрийг шинэчлэн батлах, хэрэгжүүлэхэд нөлөөлөх** | | | | | | |
| 1.3.1 | Хүний эрхийг хангах 2003 оны үндэсний хөтөлбөрийг үнэлүүлэх, шинэчлэн боловсруулах ажлыг санаачилж манлайлж оролцох;<br><br>Арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж боловсруулалтын шатанд байна гэж үзэв. | Үйл ажиллагааны зардлаар | Үнэлгээ хийгдэж, шинэчлэн боловсруулах ажилд оролцсон байна. | 0 | 100% | ХЭБСХ | “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, нийгмийн хөгжил, шаардлагад нийцүүлэн шинэчлэн батлуулж, хэрэгжүүлэх тухай саналыг ХЗДХ-ийн Сайдад хүргүүлэхээр албан бичгийн төсөл боловсруулж, удирдлагад танилцуулсан.<br>Мөн уг хөтөлбөрийг үнэлж, шинэчлэн батлуулах саналыг Засаглалын зорилтот хөтөлбөрийн төсөлд тусгаж, цахим шуудангаар 2022.06.13-нд хүргүүлсэн. | 30% |
| **Зорилт 1.4** | | **Гамшгийн онцгой нөхцөл байдал, онц байдлын үед хүний эрхийг хангах, хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох** | | | | | | |
| 1.4.1 | Онц байдал, гамшгийн үед хүний эрхийг хангаж хамгаалах үндэсний бодлого боловсруулахад чиглэсэн судалгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах; | Үйл ажиллагааны зардлаар | Судалгаа, нөлөөллийн ажил хийсэн байна. | 0 | 100% | Тамгын газар | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлийн 1 дүгээр бүлэг болох “КОВИД-19 цар тахлын хүний эрх, эрх чөлөөний сургамж” сэдэвт хэлэлцүүлгийг 2022.05.24-ний өдөр зохион байгуулсан.<br>Хэлэлцүүлэгт Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комисс, Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Онцгой байдлын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Халдварт өвчин судлалын үндэсний төв, НҮБ-ын Монгол дахь Суурин зохицуулагчийн газар, Европын холбооны төлөөлөгчийн газар, Олон Улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын төлөөлөл оролцсон ба КОВИД-19 цар тахлын хүний эрхийн сургамжид үндэслэн нийгмийн гоц халдварт | 30% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өвчнийг тандан судлах, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг тодорхойлох байгууллагын тогтолцоог үнэлж, халдварт өвчний үед нийгмийн амьдрал, хүмүүсийн олон янзын хэв байдалд нийцтэй хариу арга хэмжээг төлөвлөх бодлогын шинэ чиглэл бий болгох, мөн олон улсын байгууллагуудтай Монгол Улсын гамшгаас хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр санал солилцсон. | |
| **Стратегийн зорилго 2: Хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд үр дүнтэй хяналт тавих, бодитой, эерэг өөрчлөлт гаргах** | | | | | | | | |
| **Зорилт 2.1** | | **Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрхийн хэрэгжилтэд үр нөлөөтэй хяналт тавих, энэ чиг үүргийг хэрэгжүүлэх арга зүйг боловсронгуй болгох** | | | | | | |
| 2.1.1 | Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ (ХЭНБҮ) хийх аргачлалын дагуу уул уурхайн болон хөгжлийн бусад төслийг үнэлэх, аргачлалыг сайжруулах; | Үйл ажиллагааны болон төслийн зардлаар | Аргачлалыг боловсронгуй болгосон байна. | 50% | 60% | Тамгын газар | Дорноговь аймгийн Айраг, Даланжаргалан сум, Төв аймгийн Баянжаргалан сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын үйл ажиллагаанд Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийсэн судлаачийн тайлантай танилцаж, судалгааг сайжруулах чиглэлээр санал хүргүүлж, дахин сайжруулсан тайланг НҮБ-ын Байгаль орчны мониторингийн төслийн менежерт хүргүүлсэн. | 30% |
| 2.1.2 | Олон улсын шинжээчдийн оролцоотойгоор Монгол улсын төсөвт Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн пактаар хүлээсэн үүргийг хэрэгжүүлж байгаа байдалд дүн шинжилгээ хийх бэлтгэл ажлыг хангах; | Төслийн зардлаар | Дүн шинжилгээний ажлыг эхлүүлсэн байна. | 0 | 100% | ХЭБСХ | Комиссоос 2022.05.13-ны өдөр Монголын Эмнести интернэйшнл ТББ-аас зохион байгуулсан “Эрүүл мэндийн салбарын төсвийн мониторинг” сэдэвт хэлэлцүүлэгт оролцож мэдээлэл авсан.<br>Комиссын гишүүн Г.Нарантуяа Монгол улсын төсөвт Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн пактаар хүлээсэн үүргийг хэрэгжүүлж байгаа байдалд дүн шинжилгээ хийх боломжтой гадны орны 2 мэргэжилтэй холбогдож Комиссын дарга Женев хотод албан томилолтоор 2022.06.20-28-ны өдрүүдэд ажиллах үеэр уулзах хүсэлтийг хүргүүлсэн. | 0% |
| 2.1.3 | Боловсролын салбар дахь хүний эрхийн зарим асуудлаар хяналт, үнэлгээ хийх; | Үйл ажиллагааны зардлаар | Мониторинг хийсэн байна. | 0 | 100% | ХЭБСХ, ГХШХ | 1. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022.03.14-ний А/86 дугаар тушаалаар “Сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | салбар дахь хүний эрхийн нөхцөл байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах" үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Комиссын 3 албан хаагч ажиллаж байгаа ба хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх 3 төрлийн ажлын даалгаврыг боловсруулж БСШУ-ны сайдын 2022.05.05-ны А/156 дугаар тушаалаар, шаардагдах зардлыг БСШУ-ны сайдын 2022.05.05-ны А/157 дугаар тушаалаар тус тус батлуулж, уг ажлыг гүйцэтгэх боломжтой ТББ, судалгааны багийн жагсаалтыг гаргаж БШУЯ-нд хүргүүлсэн.<br>2. Батлагдсан төлөвлөгөөний дагуу 15 аймгийн 51 сургуулийн Дотуур байранд хяналт шалгалт хийж холбогдох албан тушаалтнуудад Комиссын гишүүний 3 зөвлөмж, 1 шаардлага хүргүүлсэн. | |
| 2.1.4 | Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; | Койкагийн төслийн зардлаар | Холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байна. | 0 | 100% | Тамгын газар | 1. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Койка олон улсын байгууллагаас хамтран хэрэгжүүлж байгаа "Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь" төслийн хүрээнд ХЭҮК-оос 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батласан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу Жендэрийн үндэсний хороотой хамтран Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн холбогдох заалтад үнэлгээ хийх, жендэрийн мэдрэмжтэй манлайлагч шалгаруулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зарыг 2022.06.10-наас 20-ныг хүртэлх хугацаанд олон нийтэд нээлттэй зарлаж, Комиссын цахим хуудсанд байршуулсан. Мөн улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдлын хэрэгжилтэд | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үнэлгээ хийх ажлын даалгаврын төслийг боловсруулсан.<br>2. Тайлант хугацаанд Сэлэнгэ, Говь-Алтай, Баян-Өлгий, Завхан, Увс аймгуудад хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. | |
| 2.1.5 | Эмэгтэйчүүдийн эдийн засгийн харилцаан дахь оролцоо, аж ахуй эрхлэх эрхийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх | Төслийн зардлаар | Дүн шинжилгээ хийсэн байх | 0 | 100% | ХЭБСХ | Төслийн санхүүжилт шийдвэрлэгдээгүй тул уг ажлыг хэрэгжүүлэх боломжгүй болсон.<br><br>Төлөвлөлт анхаарах | 0% |
| 2.1.6 | Хүний эрх ба технологи судалгаа хийх бэлтгэл ажлыг тодорхойлох; | Үйл ажиллагааны зардлаар | Бэлтгэл ажлыг хангасан байна. | 0 | 100% | ХЭБСХ | Мэдээллийн технологитой холбоотой хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн жагсаалтыг боловсруулж, Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас "Технологи ба хүний эрх" судалгааны ажлын даалгавар боловсруулахад шаардлагатай үнэлгээ, судалгааны тайланг авсан. Улмаар "Шинэ технологийн хүний эрхийн эрсдэл Монгол Улсад: бодлого, эрх зүйн орчин, нөхцөл байдал” сэдэвт судалгааны ажлыг гүйцэтгэх мэдээллийн технологийн аюулгүй байдлын мэргэжилтэнг 2022.06.20-нд сонгосон. | 50% |
| 2.1.7 | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ба хүний эрхийн талаар судалгаа, дүн шинжилгээний ажил хийх; | Үйл ажиллагааны зардлаар | Судалгаа, дүн шинжилгээ ажил хийсэн байна. | 0 | 100% | ХЭБСХ | Хугацаа болоогүй. Төлөвлөлт анхаарах /1-4 улиралд/ | 0% |
| 2.1.8 | Ахмад настны эрхийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх; | Үйл ажиллагааны зардлаар | Дүн шинжилгээ хийсэн байна. | 0 | 100% | ХЭБСХ | Ахмад настны эрхийн хэрэгжилтээр хийсэн судалгааны жагсаалтыг гаргаж, Улаанбаатар хотын гэр хороололд амьдарч буй “Ахмад настны эрх, хамгаалал” судалгааны ажлын даалгавар, удирдамжийг боловсруулж, зөвлөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зарыг 2022.05.02-ноос 20-ны өдрүүдэд олон нийтэд нээлттэй зарлаж, Комиссын цахим хуудсанд байршуулсан. Сонгон шалгаруулалтад 3 байгууллага оролцохоор холбогдох материалаа ирүүлсэн | 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бөгөөд “Мэргэжлийн социологичдын холбоо” ТББ-ыг сонгон шалгаруулж судалгааны ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулахаар ажиллаж байна. | |
| 2.1.9 | “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Монгол Улсын төрөөс авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ ба хүний эрхийн хэрэгжилт”-д дүн шинжилгээ хийж хяналт тавих; | Үйл ажиллагааны зардлаар | Дүн шинжилгээ хийж, хяналт тавьж ажилласан байна. | 0 | 100% | ХЭБСХ, ГХШХ | 1. Тайлант хугацаанд 12 байгууллагад хийсэн хяналт шалгалтын ажлын удирдамжид Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтийг шалгах заалт оруулсан ба шалгалтын мөрөөр шаардлага, зөвлөмж гараагүй. Ковид-19 цар тахалтай холбоотой 4 гомдол ирсэнийг зохих хугацаанд шийдвэрлэсэн.<br>2. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд байгууллага, албан тушаалтнаас 2020-2021 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг Сангийн яаманд, 2021 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг 2022.01.24-ний өдөр УИХ-ын түр хороонд, 2022 оны 01 дүгээр улирлын байдлаар хэрэгжүүлсэн ажлын тайланг 2022.04.13-ны өдөр УИХ-ын түр хороонд тус тус хүргүүлсэн. Уг хуулийн хэрэгжилтийн хагас жилийн тайланг боловсруулахаар холбогдох 24 байгууллага, албан тушаалтанд “Биелэлт ирүүлэх тухай” албан бичиг хүргүүлээд байна. | 50% |
| Нэмэлт | Хорих 407, 409, 421, 423, 435, 445, 457 дугаар ангиудад хяналт шалгалт хийх | ОУХБ санхүүжилтээр | Төслийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.<br><br>Хүрэх үр дүн | 20% | 100% | ГХШХ | 2022.02.17-ны өдөр Хорих 435, 445 дугаар ангид, 2022.03.04-ний өдөр Хорих 457 дугаар ангид, 2022.03.28-ны өдөр Хорих 423 дугаар ангид, 2022.04.12-ны өдөр Хорих 407 дугаар ангид, 2022.04.13-ны өдөр Хорих 409 дүгээр ангид, 2022.04.14-ний өдөр Хорих 421 дүгээр ангид тус тус хяналт шалгалт хийсэн. | 90%<br><br>Үр дүн? |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нэмэлт | “Монгол улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийг хэрэгжүүлэх | НҮБХХ санхүүжилтээр | Төслийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна. | 20% | 100% | ГХШХ | Комиссын даргын 2022.05.06-ны өдрийн А/14 дугаар тушаалаар “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь төсөл”-ийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулсан. Төслийн хүрээнд 2022 онд 4 аймагт бүсийн зөвлөлдөх уулзалт, 9 аймагт сургалт, хяналт шалгалт хийхээр төлөвлөсөн ба төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. | 50% Үр дүн? |
| Нэмэлт | Төрийн захиргааны удирдах албан тушаалтан болон төрийн тусгай албан хаагчдад сургалт зохион байгуулах | НҮБХХ санхүүжилтээр | Төслийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна. | 20% | 100% | ГХШХ | Тайлант хугацаанд Сэлэнгэ, Говь-Алтай, Баян-Өлгий, Завхан, Увс аймгуудад төрийн захиргааны болон төрийн тусгай, үйчилгээний байгууллагын удирдах албан тушаалтан болон сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга нарт сургалт зохион байгуулсан. | 100% |
| Нэмэлт | Төрийн тусгай болон үйлчилгээний албан хаагчдын ажлын байран дахь дарамт хүчирхийллийн судалгаа хийх | НҮБХХ санхүүжилтээр | Төслийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна. | 20% | 100% | ХЭБСХ | "Төрийн тусгай албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт", "Төрийн үйлчилгээний албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт" судалгааны ажлын даалгавар, сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд нээлттэй байдлаар хүргэж, 3 байгууллага холбогдох материалаа ирүүлснээс “Хөгжлийн санаачилга, бодлого судлалын төв” ТББ, Хууль зүйн үндэсний хүрээлэнгээр судалгааны ажлыг гүйцэтгүүлэхээр сонгон шалгаруулсан. | 70% |
| Нэмэлт | Бүсчилсэн зөвлөлдөх уулзалт зохион байгуулах | НҮБХХ санхүүжилтээр | Төслийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна. | 20% | 100% | ХЭБСХ | Хугацаа болоогүй. Төлөвлөлт | 0% |
| Зорилт 2.2 | | ХЭҮК-оос өмнөх жилүүдэд судалж, тодорхойлсон асуудлыг бодитойгоор шийдвэрлүүлэх идэвхтэй үйл ажиллагаа явуулах | | | | | | |
| 2.2.1 | Сэтгэцийн өвчтэй хүмүүсийн асрамжийн газар байгуулах, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар гарсан | Үйл ажиллагааны зардлаар | Тогтолцоог сайжруулахад манлайлж ажилласан байна. | 0 | 100% | ХЭБСХ | 1. ХЗДХЯ-наас боловсруулсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд сэтгэцийн өвчтэй хүмүүст эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх асуудлыг тусгуулах саналыг хүргүүлсэн.<br>2. ХЭҮК, Нээлттэй нийгэм форумтай 2022 онд хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шийдвэрийн биелэлтийг хангуулахад нөлөөлөх; | | | | | | нэвтрүүлэг хийхээр СЭМҮТ-д хийсэн хяналт, шалгалтын илтгэх хуудас, Комиссын гишүүний шаардлага, түүний хариу, хэлэлцүүлгийн материал зэрэг холбогдох мэдээллийг нэвтрүүлэг бэлтгэх сэтгүүлчид хүргүүлсэн ба нэвтрүүлгийн зохиолыг бичиж байна. | |
| 2.2.2 | Төрийн цэргийн анги байгууллагууд дахь дүрмийн бус харьцаанаас урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан дүгнэлт, зөвлөмжийн биелэлтийг хангуулах; | Үйл ажиллагааны зардлаар | Дүгнэлт, зөвлөмжийн биелэлтийг хангуулахад манлайлж ажилласан байна. | - | 100% | ХЭБСХ | 1. Төрийн цэргийн байгууллагууд дахь дүрмийн бус харьцааны судалгааны хүрээнд 2022.03.01-ний өдөр Хил хамгаалах ерөнхий газрын экспертүүдэд, 2022.03.10-ны өдөр Зэвсэгт хүчний жанжин штабын экспертүүдийг оролцуулсан 2 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Төрийн цэргийн байгууллага дахь дүрмийн бус харьцааны 3 удаагийн судалгааг эмхэтгэх, боловсруулалтыг сайжруулах ажлыг гүйцэтгэж байна.<br>2. ХЭБСХ-ээс Дотоодын цэргийн 05 дугаар ангид 2022.06.18-ны өдөр хяналт, мониторинг хийж, ажлын үр дүнг илтгэх хуудсаар Комиссын гишүүн Б.Энхболдод танилцуулсан. | 50% |
| 2.2.3 | ҮАБЗ-д улирал тутам мэдээлэл хүргүүлэх; | Үйл ажиллагааны зардлаар | Журмын дагуу мэдээлэл хүргүүлсэн байна | 4 | 8 | ХЭБСХ | Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд I улирлын танилцуулга мэдээг 2022.04.06-нд хүргүүлсэн ба II улирлын мэдээллийг нэгтгэж хүргүүлэхээр холбогдох нэгжүүдээс санал авч байна. | 30% |
| 2.2.4 | Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг үр нөлөөтэй, хараат бусаар мөрдөн шалгах нэгж бий болгох талаар өгсөн зөвлөмжүүдийг үнэлэх; | Үйл ажиллагааны зардлаар | Хувилбаруудыг тодорхойлсон байна. | 0 | 25% | ХЭБСХ, ОУГЭЗХАХ | Хугацаа болоогүй. Төлөвлөлт /1-4 улиралд/<br><br>Төлөвлөлтийг сүүлийн хагас жилд оруулах | 0% |
| Стратегийн зорилго 3. Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд манлайлах | | | | | | | | |
| Зорилт 3.1 | | Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн чадавхи бэхжүүлэх болон нөлөөллийн үйл ажиллагаа явуулах | | | | | | |
| 3.1.1 | Гадаадад оршин сууж, сурч, ажиллаж байгаа иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үр дүнтэй, байнгын ажиллагаатай | Үйл ажиллагааны зардлаар | ЗГ, УИХ-д уламжилсан байна. | 0 | 25% | ОУГЭЗХАХ | Хилийн чанад дахь Монголчуудын Зөвлөлтэй 2022.05.06-ны өдөр уулзалт хийж 06, 07 дугаар сард хамтран зохион байгуулах ажлын талаар тохиролцсон. | 0% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтолцоо болгоход Засгийн газар, Гадаад хэргийн яамны санаачлагыг дэмжиж, зөвлөн туслах; | | | | | | | |
| 3.1.2 | Төрийн албан хаагч хүний эрхийн зөрчил гаргаж байсан эсэх талаар мэдээллийн сан бүрдүүлэх тухай санал хүргүүлэх; | Үйл ажиллагааны зардлаар | Санал хүргүүлсэн байна. | 0 | 100% | Ажлын хэсэг | Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланд хүний эрхийн зөрчил гаргасан албан хаагчийн мэдээллийг оруулж байх талаарх саналыг боловсруулж Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга Ж.Эрдэнэбатад 2022.05.03-ны өдөр хүргүүлсэн. | 100% |
| **Гомдол хяналт шалгалтын чиглэлээр** | | | | | | | | |
| 3.1.3 | Хүний эрхийн асуудлаар зөвлөгөө өгөх; | Үйл ажиллагааны зардлаар | Хүний эрхийн асуудлаар зөвлөгөө өгсөн тоо | 1017 | 1100 | ГХШХ | Хүний эрхийн асуудлаар нийт 818 иргэнд 18087 минутын зөвлөгөө өгсөн. Үүнээс ГХШХ-ийн ажилтнууд 188 иргэнд 2308 минутын /утсаар 114, биечлэн 74/, орон нутаг дахь ажилтнууд нийт 630 иргэнд 15779 минутын /утсаар 138, биечлэн 487, цахимаар 5/ зөвлөгөө өгсөн.<br>Хууль зүйн зөвлөгөөг эрхийн төрлөөр ангилж үзвэл:<br>1. Хөдөлмөрлөх эрх – 246<br>2. Хууль зүйн туслалцаа авах эрх – 193<br>3. Хүүхдийн эрх – 61<br>4. Шударга шүүхээр шүүлгэх эрх – 59<br>5. Халдашгүй чөлөөтэй байх эрх – 47<br>6. Жендэрийн эрх тэгш байдал – 44<br>7. Өмчлөх эрх – 42<br>8. Төрийн албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах эрх – 31<br>9. Нийгмийн халамж хүртэх эрх – 23<br>10. Эрүүл мэндээ хамгаалуулах эрх – 16<br>11. Ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх -15<br>12. Сурч боловсрох эрх – 10<br>13. Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх – 6<br>14. Шашин шүтэх, эс шүтэх эрх – 4<br>15. Мэдээлэл авах эрх – 3<br>16. Амьд явах эрх – 3 | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 17. Хохирол нөхөн төлүүлэх эрх – 2<br>18. Чөлөөтэй зорчих эрх – 2<br>19. Эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрх – 1<br>20. Хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрх – 1<br>21. Иргэний харьяалалтай байх эрх – 1<br>22. Оршин суух газраа чөлөөтэй сонгох эрх – 1<br>23. Зохистой орон байраар хангагдах эрх – 1<br>24. Хүчирхийллээс ангид байх эрх – 1<br>25. Эрүү шүүлтээс ангид байх эрх – 1<br>26. Бусад – 4<br>ХЭҮК-оос 2022.05.01-ний өдөр Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан “Хуульчдын Про Боно өдөрлөг”, 2022.06.04-ний өдөр Сүхбаатарын талбайд Монголын өмгөөлөгчдийн холбоос зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т тус тус оролцож иргэдэд хүний эрхийн чиглэлээр хууль зүйн зөвлөгөө өгсөн. | |
| 3.1.4 | Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэх; | Үйл ажиллагааны зардлаар | Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд, хууль зүйн үндэслэл бүхий шийдвэрлэсэн эсэх | 1146 | 1250 | ГХШХ | Тайлант хугацаанд 438 гомдол, мэдээлэл хүлээн авсанаас 130 буюу 29.7 хувийг орон нутгаас ирүүлсэн гомдол эзэлж байна. Нийт гомдлын 84 буюу 19.18 хувийг цахимаар, 342 буюу 78.08 хувийг бичгээр, 10 буюу 2.28 хувийг утсаар, 2 буюу 0.46 хувийг амаар ирүүлсэн. Гомдол илгээгчийн төрлөөр ангилбал иргэн 366 буюу 83.6 хувь, төлөөлж гаргасан гомдол 44 буюу 10.0 хувь, хамтран гаргасан гомдол 28 буюу 6.4 хувийг эзэлж байна. Тайлант хугацаанд нийт 383 гомдол, мэдээллийг хуульд заасан үндэслэл журмын дагуу шийдвэрлэсэн.<br>Шийдвэрлэсэн хэлбэрээр ангилбал:<br>1. Зөрчигдсөн эрхээ сэргээлгэх талаар өөрт нь тайлбарлаж хариу өгсөн – 123<br>2. Харьяалалын дагуу холбогдох байгууллагад шилжүүлсэн – 109 | 30% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 3. Комиссын тухай хуулийн 22.2 дахь хэсэгт заасны дагуу хариу өгсөн – 36<br>4. Гомдлоосоо татгалзсан – 32<br>5. Үндэслэлгүй гомдлыг буцаасан – 25<br>6. Шаардлага хүргүүлсэн – 16<br>7. Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдлыг шалгуулахаар шилжүүлсэн – 13<br>8. Гомдлын шаардлага хангаагүй гомдлыг буцаасан – 10<br>9. Зөвлөмж хүргүүлсэн – 10<br>10. Эвлэрүүлсэн – 6<br>11. Зөвлөгөө өгсөн – 1<br>12. Бусад - 2<br>2022 оны 01 дүгээр сарын үлдэгдэл 1, 03 дугаар сарын үлдэгдэл 6, 04 дүгээр сарын үлдэгдэл 11, 05 дугаар сарын үлдэгдэл 12, 06 дугаар сард цохогдсон 19, цохогдоогүй 6 буюу нийт 55 гомдол ажиллагаанд байна. Үүнд ГХШХ-ийн ажилтнуудад 34, орон нутгийн ажилтнуудад 14, ХЭБСХ-т 1, цохогдоогүй 6 гомдол байна. | |
| 3.1.5 | Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах; | Үйл ажиллагааны зардлаар | Иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, хохирол нөхөн төлүүлэхээр шүүхэд гаргасан нэхэмжлэлийн тоо | 2 | 3- | ГХШХ | Комиссын даргын хариуцаж буй иргэн П.Нямдэлгэрийн гаргасан гомдлын мөрөөр түүнийг төлөөлөн гаргах нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангах, ирүүлсэн баримт материалд дүн шинжилгээ хийх, нотлох баримтын шаардлага хангуулах ажил хийгдэж байна. | 50% |
| 3.1.6 | Комиссын гишүүний шаардлага хүргүүлэх; | Үйл ажиллагааны зардлаар | Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд | 43 | 53- | ГХШХ | Тайлант хугацаанд Комиссын гишүүний 16 шаардлага боловсруулсан. Үүнд:<br>1. Комиссын дарга Ж.Хунан – 1<br>2. Комиссын гишүүн Х.Мөнхзул – 7<br>3. Комиссын гишүүн Г.Нарантуяа – 5<br>4. Комиссын гишүүн Д.Сүнжид – 3 шаардлагыг холбогдох албан | 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шаардлага хүргүүлсэн эсэх | | | | тушаалтнуудад тус тус хүргүүлсэн байна. | |
| 3.1.7 | Комиссын гишүүний зөвлөмж хүргүүлэх; | Үйл ажиллагааны зардлаар | Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд шаардлага хүргүүлсэн эсэх | 57 | 67- | ГХШХ | Тайлант хугацаанд Комиссын гишүүний 20 зөвлөмж боловсруулсан. Үүнд:<br>1. Комиссын дарга Ж.Хунан – 4<br>2. Комиссын гишүүн Х.Мөнхзул – 4<br>3. Комиссын гишүүн Д.Сүнжид – 11<br>4. Комиссын гишүүн Б.Энхболд -1 зөвлөмж холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн байна. | 30% |
| 3.1.8 | Гишүүний санаачилгаар болон гомдол, мэдээллийн мөрөөр хяналт шалгалт хийх; | Үйл ажиллагааны зардлаар | Хяналт, шалгалт хийсэн байх | 53 | 55+ | ГХШХ | Тайлант хугацаанд гомдлын мөрөөр 21, Комиссын гишүүний санаачилгаар 67, төслийн хүрээнд 23, албан тушаалтны хүсэлтээр 1 нийт 112 хяналт шалгалт хийгдсэн. Үүнд:<br>1. Комиссын дарга Ж.Хунан - 9<br>2. Комиссын гишүүн Х.Мөнхзул – 6<br>3. Комиссын гишүүн Г.Нарантуяа – 4<br>4. Комиссын гишүүн Д.Сүнжид – 14<br>5. Комиссын гишүүн Б.Энхболд – 8<br>6. Тамгын газрын ажилтнууд - 71 хяналт шалгалт хийсэн. | 100% |
| **Зорилт 3.2** | | **Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг бэхжүүлэх** | | | | | | |
| 3.2.1 | Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн хэлтсийг Комиссын Тамгын газарт байгуулж, хүний нөөц, орон байр, бусад материаллаг нөхцөлөөр хангах; | Үйл ажиллагааны зардлаар | Ажиллах, орчин нөхцөлийг бүрдүүлж ажилласан байна. | 0 | 100% | ЗУХ | УИХ-ын 2022.06.02-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор ХЭҮК-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээр Я.Цэлмэнг томилсон ба Тамгын газраас шинээр томилогдсон гишүүний ажлын өрөөг тохижуулж шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангаж, ажиллах хэвийн нөхцөлөөр хангах ажлыг зохион байгуулсан.<br>Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний саналын дагуу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн орон тоог 10 хүнтэй байхаар тооцож Комиссын даргын 2022.06.15-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар бүтэц орон тоог шинэчлэн баталсан. Улмаар тус хэлтэс (Хэлтсийн дарга 1, Ахлах референт 2, Референт 3, Ахлах | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэргэжилтэн 3, Мэргэжилтэн 1)-ийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинээр боловсруулж Төрийн албаны зөвлөлөөр хянуулж, зөвшөөрөл авахаар хүргүүлсэн. | |
| 3.2.2 | Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан гишүүн, хэлтсийн ажилтнуудыг Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколоор Монгол Улсын хүлээсэн үүргийг биелүүлэх чадавхыг бэхжүүлэх ажлыг олон улсын байгууллагын дэмжлэгтэй зохион байгуулах; | Төслийн зардлаар | Чадавх бэхжүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан байна. | 0 | 100% | Тамгын газар | Цар тахлын улмаас хойшилж байсан UPR Trust Fund-ийн санхүүжилттэй төслийн ЭШУСМ-тай холбоотой бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагааг дахин идэвхжүүлэх асуудлаар ГХЯ, НҮБСЗГ, НҮБХЭДКГ-тай цахим уулзалт хийж, 03, 04 дүгээр улиралд зохион байгуулах ажлын саналыг хүргүүлэхээр тохиролцсон. | 0% |
| **Зорилт 3.3** | | **Хүний эрх хамгаалагчийг хамгаалах үндэсний механизмыг бий болгож, бэхжүүлэх** | | | | | | |
| 3.3.1 | Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүдийг сонгон шалгаруулж, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн хуульчид, хүний эрхийн хамгаалагчдаас бүрдсэн Хороо байгуулах; | Үйл ажиллагааны болон төслийн зардлаар | Хүний эрх хамгаалагчийн хороо байгуулагдсан байна. | 0 | 100% | Тамгын газар | Комиссын 2022.06.03-ны өдрийн ээлжит бус 06 дугаар хуралдаанаар Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10.2-т заасны дагуу Комиссын гишүүд дотроосоо нууц санал хураалтаар олонхийн саналаар Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүнээр С.Дондов гишүүнийг сонгосон.<br>Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүдийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг<br>Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1-д заасны дагуу ХЭҮК, ХЗДХЯ, Төрийн албаны зөвлөл, Жендэрийн үндэсний хороо, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Комиссын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөлийн төлөөллөөс бүрдсэн таван хүний бүрэлдэхүүнтэй байгуулж эхний ээлжид Иргэний нийгмийн зөвлөлийн төлөөллөөр Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн гүйцэтгэх захирал Н.Арвинтариа сонгосон.<br>Хүний эрх хамгаалагчийн хорооны дүрмийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагчаар Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүн С.Дондов, гишүүдээр ОУГЭЗХАХ-ийн референт П.Оюун, ЗУХ-ийн гишүүний туслах А.Балдангомбо нар ажиллаж байгаа ба ажлын хэсгийн вакумжсан уулзалтыг 2022.06.23, 24-ний өдрүүдэд зохион байгуулж, ажлын хэсгийн гишүүдийн саналыг нэгтгэж, төслийг боловсруулж байна. | |
| 3.3.2 | Хүний эрхийг хамгаалагчийн асуудал эрхэлсэн хэлтсийг Комиссын Тамгын газарт байгуулж, хүний нөөц, орон байр, бусад материаллаг нөхцөлөөр хангах; | Үйл ажиллагааны болон төслийн зардлаар | Ажиллах, орчин нөхцөлийг бүрдүүлж ажилласан байна. | 0 | 100% | ЗУХ | УИХ-ын 2022.06.02-ны өдрийн 28 дугээр тогтоолоор ХЭҮК-ын гишүүнээр С.Дондовыг томилсон ба Тамгын газраас шинээр томилогдсон гишүүний ажлын өрөөг тохижуулж шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангаж, ажиллах хэвийн нөхцөлөөр хангах ажлыг зохион байгуулсан.<br>Комиссын даргын 2022.05.02-ны өдрийн А/13 дугаар тушаалаар Тамгын газрын бүтэц, орон тоонд өөрчлөлт оруулж Хүний эрх хамгаалагчийн Хэлтсийн дарга 1, Ахлах референт 1, Референт 1, Мэргэжилтэн 1, Төрийн үйлчилгээний ажилтан 1 нийт 5 орон тоотой байхаар батласан. Шинээр батлагдсан орон тооны өөрчлөлтийн дагуу хэлтсийн дарга нараас ирүүлсэн албан тушаалын тодорхойлолтын төслийг нэгтгэн боловсруулж, ажлын байрны шинжилгээний тайлан, албан тушаалын харьцуулалтыг тус тус боловсруулж, удирдах 8, гүйцэтгэх 32 албан тушаалын тодорхойлолтыг хянуулж, зөвшөөрөл авах хүсэлтийг 2022.05.19-ний өдөр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Албан тушаалын тодорхойлолтыг хянуулах | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | явцад албан тушаалын зорилго, зорилт хэсгийг Комиссын стратеги төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, тусгай шаардлагыг холбогдох журамд нийцүүлэн эцэслэн боловсруулж, Комиссын танилцуулгын хамт дахин албан бичгээр хүргүүлсэн. ТАЗ-өөс 2022.06.29-ний өдрийн дотор хуралдаанаар оруулахаар шийдвэрлэсэн. | |
| 3.3.3 | НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглал болон Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хүний эрх хамгаалагчийн хорооны чиг үүрэг, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах; | Үйл ажиллагааны болон төслийн зардлаар | Сурталчилгаа, нөлөөллийн кампанит ажил хийсэн байна. | 0 | 100% | Тамгын газар | 1. Комиссын 2022.06.03-ны өдрийн ээлжит бус 06 дугаар хуралдаанаар Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10.2-т заасны дагуу Комиссын гишүүд дотроосоо нууц санал хураалтаар олонхийн саналаар Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүнээр С.Дондов гишүүнийг сонгосон. Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүдийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1-д заасны дагуу ХЭҮК, ХЗДХЯ, Төрийн албаны зөвлөл, Жендэрийн үндэсний хороо, Комиссын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөлийн төлөөллөөс бүрдсэн таван хүний бүрэлдэхүүнтэй байгуулж эхний ээлжид Иргэний нийгмийн зөвлөлийн төлөөллөөр Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн гүйцэтгэх захирал Н.Арвинтариа сонгосон.<br>Хүний эрх хамгаалагчийн хорооны дүрмийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн вакумжсан уулзалтыг 2022.06.23, 24-ний өдрүүдэд зохион байгуулж, ажлын хэсгийн гишүүдийн саналыг нэгтгэж, төслийг боловсруулж байна.<br>Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглал болон Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хүний эрх хамгаалагчийн хорооны чиг үүрэг, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажил хийгдээгүй байна.<br>2. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдаж, хэрэгжиж эхэлсэнтэй | 30% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | холбоотой UPR Trust Fund-ийн санхүүжилттэй төслийн бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагааг хуульд нийцүүлэн зорилт, үйл ажиллагааг шинээр төлөвлөн хэрэгжүүлэх асуудлаар ГХЯ, НҮБСЗГ, НҮБХЭДКГ-тай уулзаж, 03, 04 дүгээр улиралд зохион байгуулах ажлын саналыг хүргүүлэхээр тохиролцсон. | |
| 3.3.4 | Хүний амь нас, эрүүл мэнд нь бодитой, ноцтой эрсдэлд орсон хүний эрхийг хамгаалагчийг хамгаалах шуурхай ажиллагааны горим тогтоох; | Үйл ажиллагааны болон төслийн зардлаар | Горим тогтоосон байна. | 0 | 100% | Тамгын газар | Хугацаа болоогүй. Төлөвлөлт /1-4 улиралд/ | 0% |
| **Стратегийн зорилго 4: Хүний эрхийн соёл, боловсролын үндэсний тогтолцоог бэхжүүлэх;** | | | | | | | | |
| **Зорилт 4.1** | | **Бүх нийтийн хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх, соёлыг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах** | | | | | | |
| 4.1.1 | Хүний эрхийн онол, эрх зүйн хэм хэмжээ, хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо, олон улсын механизмын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх; | Үйл ажиллагааны болон төслийн зардлаар | Сургалт нөлөөллийн ажиллагаа зохион байгуулсан байна | 0 | 100% | ХЭБСХ | 1. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Бизнес ба хүний эрх төсөлтэй хамтран төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан "Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог бэхжүүлэх нь:Зөрчигдсөн эрхийг сэргээх арга зам" сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг 2022.02.25, 2022.03.14-ний өдрүүдэд 2 удаа зохион байгуулсан. Уг арга хэмжээг шүүх, Үндсэн хуулийн цэц, УИХ-ын Тамгын газар, УЕП зэрэг байгууллагын судалгааны хүрээлэнгийн төлөөллийг оролцуулан 2022.05.16-нд зохион байгуулахаар товлосон боловч хойшлогдсон.<br>Монголын Үйлдвэрчний Эвлэлийн холбоотой хамтран "Үйлдвэрчний эвлэлийн сонгуульт ажилтны хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа" сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг танхим болон цахимаар 2022.06.13-нд зохион байгуулсан бөгөөд 37 эмэгтэй, 28 эрэгтэй, нийт 65 хүн хамрагдсан. Уг сургалт, хэлэлцүүлэгт "Хүний эрхийн ойлголт" сэдвээр сургалт хийж, "Хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаанд тулгарч буй асуудал, түүнийг | 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шийдвэрлэх арга зам" сэдвээр бүлгийн ажил хийлгэж, хэлэлцүүлэг зохион байгуулсан. | |
| 4.1.2 | Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй гэсэн зохицуулалтын агуулга, мөн чанарыг ойлгуулахад чиглэсэн сургалт, соён гэгээрлийн үйл ажиллагаа явуулах; | Үйл ажиллагааны болон төслийн зардлаар | Сургалт нөлөөллийн ажиллагаа зохион байгуулсан байна | 0 | 100% | ХЭБСХ | Сэлэнгэ, Говь-Алтай, Баян-Өлгий, Завхан, Увс аймгийн удирдах албан тушаалтнуудыг хамруулсан “Жендэр ба хүний эрх” сургалтын хүрээнд “Хүний эрхийн мэдрэмжтэй төрийн албаны үйл ажиллагаа”, “Шийдвэр гаргахад анхаарах хүний эрхийн асуудал” сэдэвт хичээлүүдийн агуулгад хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй тухай агуулгыг тусгасан. | 30% |
| 4.1.3 | Монголын Хуульчдын холбоогоор магадлан итгэмжлэгдсэн хичээлүүдийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах; | Үйл ажиллагааны болон төслийн зардлаар | Хөтөлбөрийг шинэчилэн боловсруулсан байна. | 0 | 100% | ХЭБСХ | Хугацаа болоогүй.<br><br>Төлөвлөлт 1-2 улиралд гэсэн байна. | 0% |
| 4.1.4 | Эмч, эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан багц цаг олгох сургалтын хөтөлбөрийг Эрүүл мэндийн хөгжлийн төвөөр магадлан итгэмжлүүлэх; | Үйл ажиллагааны зардлаар | Магадлан итгэмжлэгдсэн байна. | 0 | 100% | ХЭБСХ | Эмч, эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан багц цаг олгох сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэхэд шаардагдах материалын хамт Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлж, магадлан итгэмжлэл авч, 2022 онд “Багц цагийн сургалт” зохион байгуулах эрх бүхий байгууллагын жагсаалтад ХЭҮК бүртгэгдсэн. | 100% |
| 4.1.5 | Хөдөлмөрлөх эрхийн салбарын судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн эрхийг хангах тогтолцоог сайжруулах үе шаттай үйл ажиллагаа хийх; | Төслийн зардлаар | Нөлөөллийн ажиллагаа хийгдсэн байна. | 30% | 50% | ХЭБСХ, ГХШХ | ХЭҮК-оос 2021 онд ОУХБ-ын Европын холбооны санхүүжилт, "Зохистой хөдөлмөр ба худалдаа" төслийн дэмжлэгтэйгээр “Хүүхдийн хөдөлмөрийн чанарын судалгаа”, “Ажлын байрны дарамт, хүчирхийллийн судалгаа”-ны ажлыг гүйцэтгүүлсэн бөгөөд эдгээр судалгааны ажлын хэлэлцүүлгийг 2022.01.14-ний өдөр цахимаар болон танхимаар 40 гаруй оролцогчтой зохион байгуулсан.<br>Дээрх судалгааг хэвлэмэл бүтээл болгохоор ОУХБ-ын өгсөн зөвлөмжийн дагуу “Хүүхдийн | 100%<br><br>Үр дүн? |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөдөлмөрийн чанарын судалгаа"-г эцэслэн боловсруулж хүргүүлсэн.<br>Мөн "Хүүхдийн хөдөлмөрийн чанарын судалгаа"-ны хүрээнд гаргасан "Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт", "13 нас хүрсэн хүний эрхэлж болох хөнгөн ажлын төрөл, хөдөлмөр эрхлэлийн нөхцөл"-ийг тодорхойлсныг ОУХБ-ын эксдертүүд судалж, дахин боловсруулж, 3 удаагийн цахим уулзалтад судлаачдын хамт оролцож, судалгааны үр дүн гаргасан саналыг танилцуулсан. | |
| Нэмэлт | Хүний эрхийн үндэсний чуулганы илтгэлийг эмхэтгэх, хэвлүүлэх | Төслийн зардлаар | Илтгэлийг нэгтгэж, хэвлүүлсэн байна. | 30% | 100% | ХЭБСХ | 1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтран 2021.12.10-ны өдөр буюу "Хүний эрхийн олон улсын өдөр"-ийг тохиолдуулж Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулсан "Хүний эрхийн үндэсний форум-2021" арга хэмжээний зөвлөмжийг боловсруулж ЕТГ-аар дамжуулан холбогдох газруудад хүргүүлэх ажлыг зохион байгуулсан. Мөн ЕТГ-аас Комисст ирүүлсэн зөвлөмжийг Комиссын Тамгын газрын даргын 2022.06.20-ны ТГ-01/637 дугаар албан бичгээр МХАҮТ, МХХ, Монголын Хүний эрхийн форум, Монголын сэтгүүлчдийн эвлэл зэрэг байгууллагуудад тус тус хүргүүлсэн.<br>2. Хүний эрхийн үндэсний чуулганы үндсэн болон салбар хуралдааны 33 илтгэлийг нэгтгэх, форумд оролцогчдоос гаргасан санал, зөвлөмжийг нэгтгэж дууссан ба форумын илтгэлийг хэвлүүлэхэд бэлэн болсон. | 70% |
| **Зорилт 4.2** | | **Албан болон албан бус боловсролын тогтолцоонд хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг дэмжих** | | | | | | |
| 4.2.1 | Албан боловсролын бүх шатны сургалтын хөтөлбөрт хүний эрхийн мэдлэг олгох агуулгыг зарим хичээлийн онцлогтой уялдуулан сургалтын модулыг шинэчлэх; | Үйл ажиллагааны зардлаар | Сургалтын 2-4 модуль боловсруулж, сургалтын хөтөлбөрийг өргөжүүлэх судалгааг эхэлсэн байна. | 0 | 100% | ХЭБСХ | Хүний эрхийн сургагч багшийн 18 төрлийн гарын авлагын мэдээллийг нэмж сайжруулсан ба "Эрүүл мэндээ хамгаалуулах эрх", "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх" сэдэв 2 гарын авлагыг дахин сайжруулж эцэслэхээр боловсруулж байна. | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.2 | “Жагсаал, цуглааны үеийн хууль сахиулах ажиллагаа ба хүний эрх: Алба хаагчдыг чадавхжуулах нь” модулыг боловсруулах; | Үйл ажиллагааны зардлаар | Сургалтын модуль боловсруулсан байна. | 0 | 100% | ХЭБСХ | 1. Комиссын гишүүн Б.Энхболд, Цагдаагийн ерөнхий газар, Монголын Эмнести Интернэшнл ТББ-тай хамтран “Жагсаал, цуглааны үеийн хууль сахиулах ажиллагаа ба хүний эрх: алба хаагчдыг чадавхжуулах нь” төслийн хүрээнд "Жагсаал, цуглааны үед хүний эрхийг дээдлэн хэв журам сахиулах" гарын авлагын орчуулгыг хийлгэсэн.<br>2. Монголын Эмнести интернэшнлтэй ТББ-тай хамтран зохион байгуулсан Жагсаал цуглааны үеэр хүний эрхийн ажиглагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хариуцах эрх үүргийн талаар онолын болон хууль эрх зүйн мэдлэг олгох 2 өдрийн багц сургалтад ХЭҮК-ын Тамгын газрын 12 албан хаагчийг хамруулсан.<br>3. 2022.04.07, 08-ны өдрүүдэд болсон "Монголдоо тайван сайхан амьдаръя", 2022.05.05-ны өдөр болсон “Өөрсдөө өөрчил, үгүй бол тар”, 2022.05.09-ны өдөр болсон "Монголдоо тайван сайхан амьдаръя" жагсаалын үеэр Ерөнхий сайдад өгсөн шаардлагын хариуц нэхэх жагсаал, 2022.05.20-ны өдөр болсон Ардчилсан намын гишүүдийн Улсын Дээд шүүхийн өмнө зохион байгуулсан жагсаалуудын үеэр нийт албан хаагчид ээлжээр ажиглалт хийж, үйл ажиллагааны явцыг баримтжуулан илтгэх хуудас бичсэн. | 100% |
| 4.2.3 | Ажлын байрны дарамт хүчирхийллийн эсрэг сургалтын модулыг шинээр боловсруулах | Үйл ажиллагааны зардлаар | Сургалтын модуль боловсруулсан байна. | 0 | 100% | I-IV улирал | Хөдөлмөрийн хүрээний дарамт, хүчирхийлэл судалгааны тайланд үндэслэн сургалтын модуль боловсруулах танилцуулга, төсвийн задаргааг гарган Олон Улсын хөдөлмөрийн байгууллагад хүргүүлсэн. | 0% |
| 4.2.4 | Бэлгийн хүчирхийлэлд өртсөний улмаас хүүхэд хохирсон гэмт хэргийг мөрдөх аргачлал боловсруулах, сургалтыг модуль | НҮБ-ын Хүүхдийн сангийн зардлаар | Сургалтын модуль боловсруулж, сургалт хийсэн байна. | 0 | 100% | ХЭБСХ | 1. "Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд туслалцаа үзүүлэх нь" сэдэвт цагдаагийн алба хаагчдад зориулсан гарын авлага боловсруулж 2022.04.08-ны өдөр Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулах, сургалт зохион байгуулах | | | | | | хэрэг мөрдөх хэлтэс, дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаах тасгийн алба хаагчдад тус гарын авлагыг танилцуулж, санал авах хэлэлцүүлэг, сургалтыг зохион байгуулсан. Гарын авлагыг 2022.07.01-ний дотор НҮБ-ын Хүүхдийн санд хүлээлгэж өгөхөөр ажиллаж байгаа ба санхүүгийн тайланг НҮБ-ын Хүүхдийн санд хүргүүлсэн.<br>Мөн “Бэлгийн хүчирхийлллийн хохирогч хүүхдийн эрх зүйн байдлын талаарх олон улсын болон үндэсний хууль тогтоомжид дүн шинжилгээ хийх" судлаачдыг сонгон шалгаруулж гэрээ байгуулж, ажлын уялдаа холбоо, зохицуулалтаар хангаж ажилласан.<br>2. ЦЕГ, ГХУСАЗЗ, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран Орхон, Баянхонгор, Сүхбаатар, Дундговь, Булган, Ховд аймагт зохион байгуулсан "Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд туслалцаа үзүүлэх нь" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. | |
| 4.2.5 | Хүний эрхийн сургалт зохион байгуулах; | Үйл ажиллагааны болон төслийн зардлаар | Хүний эрхийн боловсролын цахим санд бүртгэгдсэн сургалтын тоо | 64 | 70 | ХЭБСХ, ЗУХ | Тайлант хугацаанд ХЭҮК-оос хүний эрхийн боловсрол олгох нийт 257 удаагийн 566 цагийн сургалтыг зохион байгуулж, 12,123 оролцогчийг хамруулжээ. Үүнээс 35 удаагийн 132.5 цагийн сургалтыг 4748 оролцогчтойгоор Нийслэлд, 222 удаагийн 433.5 цагийн сургалтыг 7375 оролцогчтойгоор орон нутагт тус тус хийсэн. | 100% |
| 4.2.6 | Хүний эрхийн сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулах; | Үйл ажиллагааны болон төслийн зардлаар | Сургагч багшийг 3 удаагийн сургалт хийсэн байна. | 50% | 100% | ХЭБСХ, ЗУХ | Архангай аймгийн "Тэгш тусгал" ТББ-ын орон нутгийн гишүүдэд зориулсан хүний эрхийн сургагч багш бэлтгэх ээлжит сургалтыг 2 дахь удаагаа 2022.04.18-22-ны өдрүүдэд Архангай аймгийн Эрдэнэбулган суманд зохион байгуулан ажилласан. Тус сургалтад Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүд, төрийн байгууллагуудын төлөөлөл нийт 35 ажилтан хамрагдсан ба дараагийн сургалтыг 9 дүгээр сард зохион байгуулна. Сургагч багш бэлтгэх асуудлаар ЦЕГ-тай холбогдсон бөгөөд сургагч багш нарыг чадавхжуулах сургалтыг 6 | 0% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дугаар сарын сүүлийн 7 хоногт зохион байгуулахаар ажиллаж байна. | |
| 4.2.7 | "Хүний эрхийн тухай ярилцъя" уулзалт зохион байгуулах; | “Нээлттэй нийгэм форум” ТББ-ын дэмжлэгээр | Улирал тутам зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлгийн тоо | 4 | 15 | ХЭБСХ | ХЭҮК-оос Нээлттэй нийгэм форумтай 2022 онд хамтран ажиллах төлөвлөгөөнд 3 чиглэлийн 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан ба "Хүний эрхийн тухай ярилцъя" хэлэлцүүлэг 8 удаа (бүсчилэн уулзалт 4), Хүний эрхийн ТВ ток шоуг 4 удаа, “Хүндэтгэлийн лекц”-ийг Хүний эрхийн олон улсын өдрийг тохиолдуулан 12 дугаар сард 1 удаа тус тус зохион байгуулна.<br>**"Хүний эрхийн тухай ярилцъя"** анхны уулзалт хэлэлцүүлгийг Сэлэнгэ аймагт 2022.04.25-ны өдөр зохион байгуулж Сэлэнгэ аймаг болон сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарыг оролцуулж аймаг дахь хүний эрхийн анхаарал татсан асуудлаар харилцан санал солилцсон.<br>"Хүний эрхийн тухай ярилцъя" хоёрдахь уулзалт хэлэлцүүлгийг 2022.05.27-ны өдөр “Маргаашийн Монголын дүр төрх-өнөөгийн залуусын нөхцөл байдал” сэдвийн хүрээнд зохион байгуулж Фэйсбүүк лайваар олон нийтэд хүргэсэн. Мөн Комиссын орон нутаг дахь албан хаагчдаас тухайн аймаг, орон нутагт тулгамдаж буй асуудлын мэдээллийг авч, нэгдсэн жагсаалтыг гаргасан.<br>**Хүний эрхийн ТВ ток шоу зохион байгуулах ажлын хүрээнд:**<br>1. Нээлттэй нийгэм форум, МҮОНРТ-ийн төлөөлөлтэй 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдөр уулзалт зохион байгуулж, "Цагдан хорих арга хэмжээ ба хүний эрх" сэдэвт телевизийн нэвтрүүлэг хийхээр харилцан тохиролцож, дараах ажлуудыг хийлээ. Үүнд:<br>- Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ЦХАХ-ний судалгаа авахаар албан бичиг хүргүүлэх, тоон мэдээлэлд анализ дүгнэлт хийх;<br>- ХЭҮК-т цагдан хорих арга хэмжээтэй холбоотой ирсэн гомдлын бүртгэл, | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | шийдвэрлэлт, уулзалтын тэмдэглэлийн жагсаалтыг гаргах, холбогдолтой кэйс тохиолдлыг зохиолын зураглалд оруулах;<br>- 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдөр цахимаар холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөлөлтэй уулзаж, нэвтрүүлгийн зохиолд оруулах агуулга, хөндөх асуудлыг нэгтгэх;<br>- Комиссын төлөөлөн нэхэмжлэл гаргасан жагсаалтаас холбогдох кэйсийг түүвэрлэх, зохиолын зураглалд оруулах;<br>- Үндэслэлгүй хоригдсон, өндөр барьцаа тогтоосон зэрэг кэйс тохиолдлыг Шүүх.мн цахим хуудаснаас түүвэрлэх, зохиолын төсөлд нэгтгэх;<br>- Цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээний олон улсын болон дотоодын эрх зүйн зохицуулалтыг гарган, мэдээллүүдийг нэгтгэж, Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ ба хүний эрх сэдвийн зохиолын зураглалыг 6 дэд сэдвийн хүрээнд боловсруулж, холбогдох албан тушаалтанд танилцуулсан.<br>2. ННФ, МҮОНРТ-ийн төлөөлөлтэй 2022.05.16-ны өдөр Комиссын дарга Ж.Хунан, гишүүн Г.Нарантуяа нар уулзаж, “ЕБС-ийн дотуур байр”, “Сэтгэцийн эрүүл мэндийн асуудал”, “Технологи ба хүний эрх”, “Цахим орчин дахь хүүхэд хамгаалал” сэдвээр нэвтрүүлэг хийхээр сэдэв агуулга, зохион байгуулалт, төлөвлөлтийн талаар харилцан санал солилцож, “Сэтгэцийн эрүүл мэндийн асуудал”-аар хийх нэвтрүүлгийн зохиолыг гаргахаар холбогдох судалгаа, мэдээлэл, материалыг ННФ болон МҮОНРТ-д хүргүүлсэн.<br>3. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэвтрүүлэг хийх ажлын хүрээнд Говь-Алтай, Ховд, Баянхонгор аймгийн ЕБС-ийн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дотуур байрны зураг авах ажлын зохион байгуулсан. | |
| 4.2.8 | Хүний эрхийн боловсрол олгох контент бэлтгэж, нийгмийн сүлжээгээр түгээх; | Үйл ажиллагааны зардлаар | Бэлтгэсэн контентын тоо | 74 | 100 | ХЭБСХ | Хүний эрхийн товч тайлбараар 6 постер, тэмдэглэлт өдрийн 19 постер, 10 шторк, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 5 постер, 28 дугаар сургуультай хамтран Хүүхдийн эрхийн 9 цуврал контент, Жендэрийн мэдрэмжтэй удирдагчийг сурталчлах 34 постер, 2 шторк, 5 нэвтрүүлэг, Зарлалын 2 постер,Хэлэлцүүлгийн 4 цахим баннер, Ковид-19 цар тахлын үед шийдвэр гаргагчдад зориулсан 6 постер, 2 шторк тус тус бэлтгэж иргэд, олон нийтэд түгээв. Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүүхдэд зориулан хялбаршуулан бүтээсэн комик номонд санал өгсөн. ХХЕГ-тай хамтран ажиллах төлөвлөгөөний хүрээнд хүний эрхийн ойлголт сэдвээр подкастад оролцов. | 100% |
| 4.2.9 | “Хүний эрх” эрдэм шинжилгээний сэтгүүл бэлтгэж, олон нийтэд түгээх; | Үйл ажиллагааны зардлаар | Сэтгүүлийг олон нийтэд хүргэсэн байна. | 2 | 4 | ХЭБСХ | "Хүний эрх" сэтгүүлийг эрхлэн гаргах журмыг ХЭҮК-ын даргын 2022.04.14-ний А/12 дугаар тушаалаар, сэтгүүлийн редакцийн бүрэлдэхүүнийг ХЭҮК-ын даргын 2022.04.12-ны А/10 дугаар тушаалаар шинэчлэн батласан.<br>Хүний эрх сэтгүүлд бүтээл ирүүлэх зараар 8 нийтлэл ирснийг Комиссын гишүүн Б.Энхболд, редакцын зөвлөлийн гишүүдэд хянуулсан. Редакцын зөвлөлийн гишүүдээс хяналтын хуудсаар ирүүлсэн саналыг нийтлэл ирүүлсэн хүмүүст илгээн дахин сайжруулалт хийж ирүүлэхийг хүлээж байна. Сэтгүүлийн ярилцлагыг Б.Нармандах доктороос авсан. | 50% |
| 4.2.10 | Хүний эрхийн олон улсын өдрийн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх; | Үйл ажиллагааны зардлаар | Баталсан төлөвлөгөөний дагуу арга хэмжээг зохион байгуулсан байна. | 0 | 1 | Тамгын газар | Хугацаа болоогүй.<br><br>Төлөвлөлтийг 4 дүгээр улиралд гэж төлөвлөсөн учир үнэлэхгүй. | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.11 | Хөгжлийн бэрхшээлтэй Монгол хүн нөлөөллийн ажлыг хийх; | Үйл ажиллагааны болон төслийн зардлаар | Нөлөөллийн ажлыг хийсэн байна. | 0 | 100 | ХЭБСХ | Тэргэнцэртэй иргэдийн холбооноос боловсруулсан "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн асуудлууд" 5 сургалтын модуль гарын авлагад санал өгч ажилласан. | 0% |
| 4.2.12 | Урлагаар дамжуулж хүнлэг соёлыг түгээн дэлгэрүүлэх хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлж эхлэх; | Үйл ажиллагааны болон бусад зардлаар | Хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлж эхэлсэн байна. | 0 | 100 | ХЭБСХ | Урлагаар дамжуулж хүнлэг соёлыг түгээн дэлгэрүүлэх хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлж эхлэх ажлын хүрээнд 2022.05.20-ны өдөр залуучуудад тулгамдсан хүний эрхийн асуудлаар контент бэлтгэх талаар контент бүтээгчдийн төлөөлөлтэй уулзаж үнийн санал авч, гүйцэтгэх ажлын зураглалыг боловсруулж байна. | 30% |
| Нэмэлт | Туслах малчдад зориулсан хүний эрхийн сургалтын гарын авлага боловсруулах, хэвлүүлэх | Үйл ажиллагааны болон төслийн зардлаар | Сургалтын гарын авлага боловсруулж, хэвлүүлсэн байна. | 0 | 100% | Төслийн баг | "Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд туслалцаа үзүүлэх нь" цагдаагийн алба хаагчдад зориулсан гарын авлага боловсруулах, “Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрх зүйн байдлын талаарх олон улсын болон үндэсний хууль тогтоомжид дүн шинжилгээ хийх" судлаач, зөвлөхүүдтэй гэрээ байгуулж, ажлын уялбаа холбоо, зохицуулалтыг хангаж ажилласан.<br>2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтэс, дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаах тасгийн алба хаагчдад тус гарын авлагаар санал авах хэлэлцүүлэг-сургалтыг зохион байгуулсан бөгөөд тус ажлын хүрээнд төсөв гаргах, Холидэй Инн УБ-тай гэрээ байгуулах, оролцогчид урих тухай албан бичиг төлөвлөх зэрэг зохицуулалтын ажлыг хийж гүйцэтгэв.<br>ЦЕГ, ГХУСАЗЗ, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран Орхон, Баянхонгор, Сүхбаатар, Дундговь, Булган, Ховд аймагт зохион байгуулсан "Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд туслалцаа үзүүлэх нь" сургалтын | 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөтөлбөр боловсруулах, зохицуулалтын ажлыг гүйцэтгэв. Дүн шинжилгээг судлаач, зөвлөхөөс эцсийн байдлаар хүлээж авсан. Гарын авлагыг 2022.07.01-ний дотор НҮБ-ын Хүүхдийн санд хүлээлгэж өгөхөөр ажиллаж байна. Санхүүгийн тайланг НҮБ-ын Хүүхдийн санд хүргүүлсэн. | |
| Нэмэлт | Туслах малчны үндсэн модульд зориулсан хүний эрхийн сургалт сурталчилгаа, нөлөөлийн үйл ажиллагаа явуулах | Үйл ажиллагааны зардлаар | - | 0 | 100% | Төслийн баг | Хүний эрхийн Үндэсний Комиссоос хүний эрхийн боловсрол олгох сургалтыг хагас жилийн байдлаар Нийслэлд 35 удаагийн 132.5 цагийн сургалтад 4748 оролцогч, Орон нутагт 222 удаагийн 307 цагийн сургалтад 7375 оролцогчийг тус тус хамруулсан.<br>Тайлант хугацаанд нийт 257 удаагийн 429.5 цагийн сургалтад 12,123 оролцогчийг хамруулсан. | 100% |
| Нэмэлт | Ажлын байрны дарамт хүчирхийллийн эсрэг сургалтын модулыг шинээр боловсруулах; | Үйл ажиллагааны зардлаар | Сургалтын модуль боловсруулсан байна. | 0 | 100% | ХЭБСХ | Архангай аймгийн "Тэгш тусгал" ТББ-ын орон нутгийн гишүүдэд зориулсан хүний эрхийн сургагч багш бэлтгэх ээлжит сургалтыг 2 дахь удаагаа 2022 оны 04 дүгээр сарын 18-22-ны өдрүүдэд Архангай аймгийн Эрдэнэбулган суманд зохион байгуулан ажилласан. Тус сургалтад Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүд, төрийн байгууллагуудын төлөөлөл нийт 35 ажилтан хамрагдсан.<br>Сургагч багш бэлтгэх асуудлаар ЦЕГ-тай холбогдсон бөгөөд сургагч багш нарыг чадавхжуулах сургалтыг 6 дугаар сарын сүүлийн 7 хоногт зохион байгуулахаар төлөвлөж байна. | 0% |
| Нэмэлт | Хүний эрхийн боловсролын бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах | Үйл ажиллагааны зардлаар | Төслийг боловсруулсан байна. | 0 | 30% | ХЭБСХ | Боловсролын багц хуулийн төсөл батлагдсаны дараа хүний эрхийн боловсролын талаарх саналаа хүргүүлэх чиглэлийг Комиссын гишүүн Д.Сүнжид өгсөн бөгөөд уг хууль батлагдсаны дараа саналаа хүргүүлэхээр төлөвлөж байна. | 0% |
| Нэмэлт | Олон нийтийн лекц зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | Лекцийг зохион байгуулсан байна. | 0 | 1-ээс доошг | ХЭБСХ | Хугацаа болоогүй.<br>Төлөвлөлтийг /1-4 улирал/ зөв хийх | 0% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үй удаа | | | |
| **Стратегийн зорилго 5. Хүний эрхийн салбарт олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх** | | | | | | | | |
| **Зорилт 5.1** | | **НҮБ-ын хүний эрхийн механизмтай ажиллах үндэсний чадавхыг бэхжүүлэх** | | | | | | |
| 5.1.1 | Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн механизмаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, Засгийн газрын оновчтой бүтэц бий болгоход нөлөөллийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх; | Үйл ажиллагааны зардлаар | Холбогдох байгууллагад тухай бүр санал өгсөн байна. | 0 | 100% | ОУГЭЗХАХ | Комиссоос УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2022.03.30-ны өдрийн олон улсын олон талт 4 гэрээний хэрэгжилтийг хэлэлцүүлэх хуралд оролцсон. Мөн 2022.04.04-ний өдөр УИХ-ын байнгын хороод болон хамаарах гэрээдийн хэрэгжилтийн асуудлаар хариуцсан яамдын бэлтгэл хангах асуудлаар цахим хуралд оролцсон. | 30% |
| 5.1.2 | НҮБ-ын Хүний эрхийн хамгаалах тогтолцооны байгууллагуудтай хамтран ажиллах; | Үйл ажиллагааны зардлаар | Мэдээлэл хүргүүлж хамтарч ажилласан байна. | 0 | 100% | ОУГЭЗХАХ | Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын 10 дугаар тайланд Комиссын хөндлөнгийн илтгэлийг боловсруулж хүргүүлсэн.<br>Хорооны 82 дугаар хуралдаанд Комиссын дарга Ж.Хунан, Комиссын гишүүн Д.Сүнжид нар 2022.06.20-ноос 24-ний өдрүүдэд оролцож мэдээлэл хийсэн.<br>Тайлант хугацаанд мэдээлэл солилцоо яваагүй. | 50% |
| **Зорилт 5.2** | | **Олон улсын хүний эрхийн эрх зүйг хэрэглэх үндэсний чадавхыг бэхжүүлэх** | | | | | | |
| 5.2.1 | НҮБ-ын хүний эрхийн механизмаас Монгол Улсад өгсөн зөвлөмжүүдийг Засгийн газрын байгууллагуудаас НҮБ-ын гэрээний хороодоос гаргасан ерөнхий зөвлөмжийг орчуулах, практик хэрэглээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх; | Үйл ажиллагааны зардлаар | Холбогдох байгууллагууда д зөвлөмжийг уламжилсан байна. | 0 | 25% | ОУГЭЗХАХ | НҮБ-ын Хүний эрхийн хорооны тайван жагсаал, цуглаан хийх эрхийн тухай 2020 оны 37 дугаар ерөнхий тайлбар зөвлөмж (21 дүгээр зүйл)-ийг орчуулж, хяналт хийн Комиссын хэрэглээнд ашиглаж байна.<br>НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах хорооны 35 дугаар зөвлөмжийг орчуулж, хяналтад шилжүүлсэн. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.2.2 | “Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулахад үр нөлөөтэй ярилцлага хийх тухай зарчим”-ыг хууль сахиулах байгууллагуудад нэвтрүүлэх | ЭШУСН-тэй хамтарсан Төсөл хэрэгжүүлэх | Нөлөөллийн аян зохион байгуулж Мендезийн зарчмыг цахим болон бусад хэлбэрээр түгээсэн байна. | 0 | 100% | ОУГЭЗХАХ | 2021 оны 12 дугаар сард Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэгтэй хийсэн цахим уулзалтаар тохиролцсоны дагуу Медезийн зарчмыг Монгол Улсад сурталчилан таниулах, хууль сахиулах байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлэх асуудлаар хэрэгжүүлэх төслийн санал болон хамтран ажиллах санамж бичгийн төслийг боловсруулан тус Нийгэмлэгт хүргүүлэв.<br>Мендезийн Зарчмыг Монгол хэл рүү орчуулж, хууль сахиулах байгууллагуудад танилцуулах бэлтгэл ажлыг хангав.<br>Мөн Комиссын дарга тэргүүтэй төлөөлөл Женев хотод 2022 оны 6 дугаар сарын 23-нд тус нийгэмлэгтэй хийх уулзалтыг зохион байгуулав. | 50% |
| **Зорилт 5.3** | | **Олон улсын болон бүс нутгийн түвшинд Хүний эрхийн Үндэсний Комиссын байр суурь, оролцоог нэмэгдүүлэх** | | | | | | |
| 5.3.1 | Бүс нутгийн болон олон улсын сүлжээ байгууллагуудтай олон талт түншлэлийг хөгжүүлэх, үйл ажиллагаанд идэвхтэй оролцох; | Үйл ажиллагааны болон төслийн зардлаар | Оролцоог хангаж ажилласан байна. | 0 | 25 | ОУГЭЗХАХ | *-АНДЧ-ны Магадлан итгэмжлэх асуудлаарх сургалтын шинэ хөтөлбөрт Комиссын зүгээс туршлага хуваалцаж оролцох боломжтой эсэхийг асуусан мэйлд Комисс оролцоход бэлэн талаар хариу өгсөн болно*<br>*- НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн химийн хорт бодис ба хүний эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгчээс ирсэн асуулгыг бөглөж байна. Гишүүдэд танилцуулж, 3 дугаар сарын 7 гэхэд хүргүүлсэн байх ёстой.*<br>*-ОУХБ-тай Ялтны хөдөлмөрийн судалгааны хүрээнд ОУХБ-руу холбогдох судалгааны материалуудыг орчуулж цагт нь хүргүүлсэн.*<br>*-Азийн санд холбогдох санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны тайланг боловсруулж цаг тухайд нь хүргүүлсэн.*<br>*- Ази, номхон далайн бүсийн форумын Хүний эрхийн шинэ төсөл, төлөвлөлтийн менежер Фасоха Айшаттай онлайн (zoom)-р уулзалт хийж ХЭҮК-ийн алба хаагчдад ирэх 10 дугаар сард “Бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг Комиссын үйл ажиллагаанд интеграцчилах нь” дотоод сургалтыг НҮБ-ын хүн амын сан* | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | *болон Ази, номхон далайн бүсийн форумын дэмжлэгтэйгээр хийх талаар санал солилцов.*<br>*-НҮБ-ын хүүхдийн сангаас санхүүжүүлэх “Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийг хамгаалах” талаар удирдамж боловсруулах төслийн саналыг орчуулав.*<br>*- Казахстан улсын Хүний эрхийн омбудсменд тус улсад суугаа Монгол Улсын иргэдийн эрхийг хамгаалах асуудлаар албан бичиг төлөвлөн хүргүүлэв.*<br>*- АНДЧ-ны Магадлан итгэмжлэх асуудлаарх сургалтын шинэ хөтөлбөрт 2 дугаар сарын 14-ний өдөр Комиссын зүгээс панел хэлэлцүүлэгт туршлага хуваалцаж оролцов.*<br>*-ОУХБ-тай Ялтны хөдөлмөрийн судалгааны хүрээнд ОУХБ-руу холбогдох судалгааны арга зүйг орчуулж, ОУХБ-ын саналын дагуу засаж цагт нь хүргүүлсэн. 02 дугаар сарын 14-ний өдөр ээлжит санал солилцох цахим уулзалт ОУХБ-тай зохион байгуулж судалгааны арга зүйг эцэслэж цаашид гишүүн, алба хаагчид талбарт судалгаа хийх боломжтой болсон. Орчуулагчтай синхрон орчуулга хийлгэхээр холбогдож ажил гүйцэтгэх гэрээ байгуулж цахим уулзалтын дараа ажил дүгнэх акт бичсэн.*<br>*- НҮБ-ын СЗГ-тай хамтран НҮБ-ын ХЭДКГ-тай цахим уулзалт зохион байгуулж UPR Trust Fund-төслийн хүрээнд 2022 онд зохион байгуулах үйл ажиллагаатай холбогдуулан Комиссын шинээр томилогдох гишүүдийн сонгон шалгаруулах үйл явц болон Олон улсын гэрээний хэрэгжилтийг үнэлэх УИХ-ын Ажлын хэсгийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хийж, санал мэдээлэл солилцов.*<br>*- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэгтэй хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэхээр цахим шуудангаар харилцав.* | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | *- ЕАБХАБ-ын АИХЭГ-ын Жагсаал, цуглааны үед хууль сахиулах гарын авлагыг орчуулж, сургалт зохион байгуулах нь чиглэлээр мэйлээр харилцаж, 5 дугаар сарын 23-ны өдөр цахим уулзалт зохион байгуулж, зохион байгуулалтын асуудлаар санал солилцов.* | |
| 5.3.2 | Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Дэлхийн Холбооны (ХЭҮБДХ) ээлжит хуралд Комиссын төлөөлөл оролцох; | Үйл ажиллагааны зардлаар | Бэлтгэл ажил хангагдаж, хугацаандаа арга хэмжээнд оролцож, илтгэх хуудас бичигдсэн эсэх | 0 | Тийм | ОУГЭЗХАХ | *Хуралд зориулсан бичлэг хийлгэж хүргүүлэх ажлыг зохион байгуулав. Комиссоос оролцох төлөөллийг бүртгүүлэв. Комиссын дарга Ж.Хунан, Комиссын гишүүн Г.Нарантуяа, Д. Сүнжид нар тус хуралд оролцов.* | 90% |
| 5.3.3 | Ази Номхон Далайн бүс нутгийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын Чуулганы (АНДЧ) ээлжит хуралд Комиссын төлөөлөл оролцох; | Үйл ажиллагааны зардлаар | Бэлтгэл ажил хангагдаж, хугацаандаа арга хэмжээнд оролцож, илтгэх хуудас бичигдсэн эсэх | 0 | Тийм | ОУГЭЗХАХ | Хугацаа болоогүй | - |
| 5.3.4 | Ази Номхон Далайн бүс нутгийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын Чуулганы Ажлын албаны дарга нарын ээлжит хуралд Комиссын төлөөлөл оролцох; | Уригч байгууллагын зардлаар | Бэлтгэл ажил хангагдаж, хугацаандаа арга хэмжээнд оролцож, илтгэх хуудас бичигдсэн эсэх | 0 | Тийм | ОУГЭЗХАХ | Хугацаа болоогүй | - |
| 5.3.5 | Евразийн Омбудс байгууллагуудын Ээлжит хуралд Комиссын төлөөлөл оролцох; | Уригч байгууллагын зардлаар | Бэлтгэл ажил хангагдаж, хугацаандаа арга хэмжээнд оролцож, илтгэх хуудас бичигдсэн эсэх | 0 | Тийм | ОУГЭЗХАХ | Хугацаа болоогүй.<br><br>Төлөвлөлт 2 дугаар улиралд төлөвлөгдсөн байна. Төлөвлөлт анхаарах | 0% |
| 5.3.6 | Хүний эрхийн чиглэлээр олон улсын хурал, сургалт | Уригч байгууллагын зардлаар | Бэлтгэл ажлыг хангаж, хугацаанд нь | 0 | Тийм | ОУГЭЗХАХ | - Ази, номхон далайн бүсийн Чуулганаас зохион байгуулсан Гомдол, хяналт шалгалтын | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | семинарт ажилтнуудыг хамруулах бэлтгэл ажлыг хангах; | | арга хэмжээнд хамрагдан илтгэх хуудас бичигдсэн эсэх | | | | онлайн сургалтанд ахлах мэргэжилтэн Б.Болор уг сургалтанд сууж төгсөв.<br>-НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба болон БНСУ-ын Статистикийн төвийн хамтарсан Ази, Номхон далайн орнуудын Гэмт хэрэг, эрүүгийн эрх зүйн байдлын статистикийн мэргэжлийн төв (CoE), мөн НҮБ-ын Ази, Номхон Далайн Статистикийн Хүрээлэн (SIAP)-ээс “Гэмт хэргийн статистикийг жендэрийн үүднээс судлах хоёр дахь удаагийн цахим сургалт”-ын төслийн зарын дагуу ХЭҮК-ийн зарим алба хаагчид бүртгүүлж хичээлдээ сууж байна.<br>- ЕАБХАБ болон ЕТХЭҮБС-нээс хамтран зохион байгуулж буй ХЭҮБ-ын Академи ээлжит сургалтад хэлтисйн дарга Ө.Ундрах бүртгүүж, 6 дугаар сарын 20-24-ний өдөр хамрагдав. | 90% |
| 5.3.7 | Хүний эрхийн чиглэлээр төслийн 2 хүртэл санал боловсруулж санхүүжүүлэгч байгууллагад хүргүүлэх; | Үйл ажиллагааны зардлаар | төслийн санал боловсруулж тэтгэлэг олгогч байгууллагад хүргүүлсэн байна. | 0 | 100% | ОУГЭЗХАХ | ЕАБХАБ-ын АИХЭГ-аас гаргасан Тайван замаар цуглаан хийх асуудлаарх гарын авлагыг орчуулж, хууль сахиулагчдад сургалт зохион байгуулах төсөл хэрэгжүүлэх боломжийг төслийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын жагсаалтын хамтаар мэйлээр хүргүүлж, цуварл цахим уулзалтын хүрээнд 9 дүгээр сард цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтан 20, сургагч багшаар мэргэших 15 алба хаагчийг хамруулан сургалт зохион байгуулахаар тохиролцлоо. | 70% |
| 5.3.8 | Комиссын дарга, гишүүдийн хамтрагч байгууллагуудтай хийх уулзалтыг зохион байгуулах; | Үйл ажиллагааны зардлаар | Тэмдэглэл хөтөлж, гаргасан санал, шийдвэрийг баталгаажуулж хэрэгжилтийг хангасан байна. | 0 | Тийм | ОУГЭЗХАХ | Тайлант хугацаанд дараах албан тушаалтан, байгууллагатай уулзалт нийт уулзалт зохион байгуулан, оролцож тэмдэглэл хөтлөн шийдвэрийг баталгаажуулав. Үүнд:<br>- Үйлдвэрчний эвлэлийн ерөнхийлөгч С.Эрдэнэбаттай хийсэн уулзалт<br>- ТАЗ-ын даргатай хийсэн уулзалт.<br>- НҮБ-ын Хүүхдийн Сангийн суурин төлөөлөгч Эваристе Куасси-Комлан<br>- Швейцарийн Холбооны Улсын Женевт суух Монгол Улсын байнгын төлөөлөгч Д.Гэрэлмаа | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгч Гленк Феликс<br>- НҮБ-ын Хүн амын сан, шинээр томилогдсон ажлын албаны дарга Халид Шарифи<br>- Шведийн Хаант Улсын Парламентын гишүүдийн төлөөлөл<br>- НҮБ-ын Хүний эрх ,хүмүүнлэгийн Женев Акаkдеми,<br>- Хүний эрхийн төлөө олон улсын үйлчилгээ ISHR: Нью Иорк дахь захирал, хуулийн зөвлөх Тэсс Макэвой<br>- НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эсрэг тусгай илтгэгч Рийм Алсалэм<br>- НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газрын Хэсгийн дарга Роари Манговон, Хүний эрхийн төлөв байдлын хэлэлцүүлгийн асуудал хариуцсан нэгжийн хүний эрхийн мэргэжилтэн У Жон-гиль, Ази-Номхон далайн Хэсгийн мэргэжилтэн Себастиен Гиллиоз<br>- ХЭҮБДХ-ны Женев дахь төлөөлөгч Катарин Рөүз<br>- ОУХБ-ын Бодлогод суурилсан судалгаа, судалгаа, үнэлгээний нэгжийн дарга Филипп Ванхүнэгэм, төслийн ажилтан Мариа Габриэлла Брэглиа<br>- НҮБ-ын ХЭДКГ-ын хөгжих эрхийн Хэлтсийн дарга А.Бат-Эрдэнэ<br>- НҮБ-ын ХЭДКГ-ын эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хэлтсийн дарга Праадийп Ваглэ<br>- НҮБ-ын Тайван жагсаал цуглаан хийх эрхийн асуудал хариуцсан тусгай илтгэгч Клэмэнт Ниалэцосси<br>- НҮБ-ын ЭЗНСЭХ-ны ажилтан Ким Жүнг Рин<br>- Женев дэх Фрийдрих эбэрийн сангийн Хүний эрх ба хөгжлийн хөтөлбөрийн ажилтан Саломэ Лийнэрт, Ира Гибсон, туслах Маттиас<br>- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэгийн Ерөнхий нарийн бичгийн даргын | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | орлогч Аудрей Оливер Муралт, ахлах зөвлөх Бен Бакленд<br>- Дэлхийн оюуны өмчийн газрын Зохиогчийн эрх зохицуулалтын хэлтсийн Хүртээмжтэй ном консорциумын Ажлын албаны дарга Моника Халил Лөвблад | |
| 5.3.9 | Иргэний нийгмийн зөвлөлийн ээлжит хурлыг зохион байгуулах; | Үйл ажиллагааны зардлаар | Бэлтгэл ажлыг нь хангаж, хугацаанд нь зохион байгуулан, шийдвэрийг нь баталгаажуулсан хурлын тоо | 0 | 4 | ОУГЭЗХАХ | - Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөлийн дүрмийг шинэчлэн баталсантай холбогдуулан Комиссын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх материал хүлээж авахаар цахим хуудаст зарыг байршуулж Иргэний болон улс төрийн эрхээр мэргэшсэн 5, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхээр мэргэшсэн 5, бусад эрхээр мэргэшсэн 8 төлөөллийн сонгон шалгаруулж, ИНЗ-ийн бүрэлдэхүүнийг байгуулах тушаалын төслийг боловсруулж, Комиссын даргын 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/16 дугаар тушаалаар Иргэний нийгмийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсан.<br>- Комиссын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөлийн бүрэлдэхүүн 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 14-17 цагийн хооронд Бишрэлт зочид буудлын роял танхимд анхдугаар хурлыг зохион байгуулав. Хурлын зохион байгуулалттай холбоотой тушаалын төсөл, хурлын хөтөлбөр, тус гишүүдэд олгох үнэмлэх, хурлын зар түгээх, төсөв батлуулах, Комиссын гишүүдээс санал авах, шаардлагатай илтгэл зэргийг бэлтгэв. Хурлын тэмдэглэлийг албажуулахаар ажиллаж байна.<br>- Мөн Иргэний нийгмийн зөвлөлийн бүрэлдэхүүнтэй мэдээллийг шуурхай солилцох зорилгоор фэйсбүүк группийг нээв.<br>- Энэ удаагийн хуралд танхимаар 14, Швед улсаас 1 гишүүн оролцсон бол орон нутагт 1, АНУ-д 1, Турк улсад 1 гишүүн албан | 30% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | томилолтой шалтгаанаар хуралд оролцож чадаагүй болно. | |
| 5.3.10 | "ХЭҮК, ИНБ-уудын хамтын ажиллагаа" ээлжит уулзалтыг зохион байгуулах; | Үйл ажиллагааны зардлаар | Бэлтгэл ажлыг нь хангаж, хугацаанд нь зохион байгуулсан уулзалтын тоо | 0 | 2 | ОУГЭЗХАХ | Уулзалтын бэлтгэл ажлыг хангаж иргэний нийгмийн төлөөлөл 50 оролцогчийг хамруулан 4 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулав. | 100% |
| 5.3.11 | Монгол Улс дахь олон улсын байгууллагуудтай Тогтвортой хөгжил-Хамтын ажиллагаа ээлжит уулзалтыг зохион байгуулах; | Үйл ажиллагааны зардлаар | Бэлтгэл ажлыг хангаж, хугацаанд нь зохион байгуулсан уулзалтын тоо | 0 | 2 | ОУГЭЗХАХ | Тайлант хугацаанд уг уулзалтыг төлөвлөж зохион байгуулах ажил хийгээгүй. | 0% |
| 5.3.12 | Орон нутгийн удирдлагуудтай хамтын ажиллагааны уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах; | Үйл ажиллагааны зардлаар | Тухай бүр нь уулзалт зохион байгуулж, хамтран ажилласан байна. | 0 | 10 | ЗУХ | Тайлант хугацаанд Комиссын гишүүд 13 аймаг (Орхон, Сэлэнгэ, Булган, Дархан-Уул, Ховд, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Сүхбаатар, Дундговь, Баян-Өлгий, Завхан, Увс)-т ажиллаж, орон нутгийн удирдлагуудтай уулзаж, мэдээлэл солилцсон. Комиссоос аймаг тус бүрт ажиллаж буй албан хаагчид уулзалт товлож, зохион байгуулалтыг хангаж ажилласан.<br>Орон нутаг дахь албан хаагчид нийт 25 сумдад Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу ажиллаж, сумын удирдлагуудтай уулзаж, хүний эрхийн нөхцөл байдлын талаар мэдээлэл солилцож ажилласан. Үүнд:<br>- Баян-Өлгий аймаг дахь ахлах шинжээч Л.Уранчимэг Баян-Өлгий аймгийн Улаан хус, Толбо, Дэлүүн, Булган сумд;<br>- Өмнөговь аймаг дахь референт Г.Нарангоо Өмнөговь аймгийн Цогт-Овоо, Баян-Овоо, Баяндалай сумд;<br>- Дорнод аймаг дахь референт Д.Дугарсүрэн Дорнод аймгийн Цагаан-Овоо, Баяндун, Сэргэлэн сумд; | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Дундговь аймаг дахь референт Т.Баярцэцэг Дундговь аймгийн Өндөршил, Гурвансайхан, Луус, Хулд сумд;<br>- Сэлэнгэ аймаг дахь ахлах шинжээч Д.Гантулга Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн, Сант, Орхон, Орхонтуул сумд;<br>- Увс аймаг дахь референт Я.Хонгорзул Увс аймгийн Зүүнхангай, Өндөрхангай, Баруунтуруун, Цагаанхайрхан сумд;<br>- Архангай аймаг дахь референт С.Мөнгөнзаяа Архангай аймгийн Өлзийт, Өгийнуур, Хашаат сум | |
| **Стратегийн зорилго 6. Хүний эрхийн Үндэсний Комиссын чадавхыг бэхжүүлэх** | | | | | | | | |
| **Зорилт 6.1** | | **Комисс нь иргэдэд нээлттэй, ил тод, хүртээмжтэй, хүрэлцээтэй үйл ажиллагаагаа явуулах байртай болох** | | | | | | |
| 6.1.1 | Комиссын байр барих газар, хөрөнгийг шийдвэрлүүлэх нөлөөллийн ажиллагаа явуулах; | Үйл ажиллагааны зардлаар | Комиссын байр барих газар, хөрөнгийг шийдвэрлүүлэх нөлөөллийн ажиллагаа хийгдсэн байна. | 0 | 100% | ЗУХ | Газар, төсөвтэй холбоотой асуудлаар тодорхой ажил хийгдээгүй. | 0% |
| **Зорилт 6.2** | | **Хүний эрхийн хяналт, шалгалт, гомдол шийдвэрлэх, хүний эрхийн зөвлөгөө өгөх үйл ажиллагааг боловсронгуй болгох** | | | | | | |
| 6.2.1 | Гомдол шалгах, шийдвэрлэх, хяналт шалгалтын үйл ажиллагааны дотоод журмыг шинэчлэх, гомдол шалгах, хяналт шалгалт хийх гарын авлага боловсруулж, ажилтнуудын чадавхыг нэмэгдүүлэх; | Үйл ажиллагааны болон төслийн зардлаар | Гарын авлага боловсруулж, хэрэгжүүлсэн байна. Журам шинэчлэгдэн батлагдсан байна. | 40% | 100% | ГХШХ | Гомдол шалгах, шийдвэрлэх, хяналт шалгалтын үйл ажиллагааны журмын төслийг шинэчлэн боловсруулж Г.Нарантуяа гишүүнд 2022.05.16-ны өдөр танилцуулсан. Уг журмын шинэчлэлтэй холбоотойгоор Комиссын гишүүд болон ГХШХ-ийн ажилтнууд, бичиг хэргийн ажилтан оролцсон уулзалтыг 2022.05.27-ны өдөр зохион байгуулж, хэлэлцүүлсэн. Комиссын гишүүд болон ГХШХ-ийн ахлах референт журмын төслийн тодорхой бүлгийг хариуцан боловсруулахаар шийдвэрлэж, Комиссын гишүүн Д.Сүнжид, Б.Энхболд болон ГХШХ-ээс журмын төслийн холбогдох хэсгийг дахин боловсруулж | 30% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | гишүүдэд болон референт Д.Ёндонжамцад илгээсэн. | |
| 6.2.2 | ХЭҮК-ын гомдол шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх; | Үйл ажиллагааны болон төслийн зардлаар | Дүн шинжилгээ хийсэн байна. | 0 | 100% | ГХШХ | ХЭҮК-ын гомдол шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийж журмыг шинэчлэхээр ажиллаж байна. | 50% |
| 6.2.3 | Байгууллагын үйл ажиллагааны талаар статистик мэдээлэл гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх; | Үйл ажиллагааны зардлаар | Нэгж тус бүрийн хариуцсан чиг үүргийн хүрээнд мэдээллийн сан бий болсон байна. | 0 | 100% | Тамгын газар, ЗУХ | Комиссын 2022 оны үйл ажиллагааны 01, 02 дугаар улирлын статистик тоон мэдээллээр инфофафик гарган цахим сүлжээнд байршуулсан. Мөн УИХ-ын хаврын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тов дараалльг 7 хоног бүрээр гаргаж Комиссын гишүүд, Тамгын газрын дарга нарт тогтмол мэдээлж ажилласан. | 90% |
| **Зорилт 6.3** | | **Иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтын ажиллагааны үр дүнтэй түншлэлийг бэхжүүлэх** | | | | | | |
| 6.3.1 | Комиссоос хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах стратегийг боловсруулж хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны болон төслийн зардлаар | Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан байна. | 0 | 100% | ЗУХ | ХЭҮК-оос хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааны чиглэлээр “Бүүст Медиа Монголиа” ХХК-тай зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж ажилласан бөгөөд тус байгууллагаас нэг талаас мэдээ мэдээллийг сэтгүүлчид болон мэдээллийн хэрэгсэл, сошиал хуудсуудаар дамжуулан олон нийтэд хүргэх, нөгөө талаас олон нийтээс болон сэтгүүлчдээс мэдээ мэдээлэл хүлээн авахын зэрэгцээ, хамтран ажиллах хүрээний асуудлыг тусгасан бодлогын баримт бичгийг хүлээлгэн өгсөн. | 70% |
| 6.3.2 | Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах. | Үйл ажиллагааны зардлаар | Мэдээллээр хангасан иргэдийн тоо | 10 | 20 | ЗУХ | 1. Төрийн захиргааны удирдах 1, гүйцэтгэх 6 албан тушаалын сул орон тооны захиалгын дагуу Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд ил тод зарлагдаж 3 хүнийг шилжүүлэн томилж, Мэдээллийн технологийн ажилтны сул орон тооны зарыг байгууллагын цахим хуудас болон пейж хуудсаар нийтэд ил тод байршуулсан.<br>Комисын ажлаас чөлөөлөгдсөн 2, шинээр томилогдсон 7 албан хаагчийн мэдээлэл, Байгууллагын дэргэдэх Ёс зүйн зөвлөл байгуулсан тухай Тамгын газрын даргын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2022.05.12-ны өдрийн А/29 дүгээр тушаалыг тус тус байгууллагын цахим хуудсанд оруулсан.<br>2. Тайлант хугацаанд ХЭҮК-ын байранд биечлэн ирсэн 5, фэйсбүүк хуудсаар дамжуулан 5, утсаар 6 нийт 16 иргэнд Комиссын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл өгсөн.<br>2022 оны хагас жилийн байдлаар ХЭҮК-ын байранд биечлэн ирсэн 5, фэйсбүүк хуудсаар дамжуулан 5, утсаар 6 нийт 16 иргэнд Комиссын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл өгсөн. Үүнд:Текст, зурагт хуудас хэлбэрээр цаг үеийн мэдээ, мэдээллийг хүргэж, цахим хуудаст орсон мэдээллийг фэйсбүүк, твиттер хуудсаар давхар иргэд олон нийтэд хүргэсэн. Үүнд:<br>- “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэл” файлаар авах;Цэргийн алба хаагчдын дүрмийн бус харилцаанд хийсэн судалгааг хаанаас авах;<br>- Ажлын байрны бэлгийн дарамтын талаарх судалгаа хэвлэмээр авах<br>- Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд оноож буй ял шийтгэлийн нөхцөл байдлын судалгаа байгаа эсэхийг лавлаж;<br>- Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой судалгаа байгаа юу?<br>- Хүн худалдаалах гэмт хэргийн статистик тоог хаанаас авч болох вэ?<br>- Танайд гомдол гаргахын тулд заавал биечлэн очих шаардлагатай юу?<br>- Өсвөр насны ЕБС-ийн сурагчдын дунд үе тэнгийн дээрэлхэлт их гарч байгаа учраас хаана, хэнд гомдол гаргах вэ? | |
| 6.3.3 | Комиссын явуулж буй үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр | Үйл ажиллагааны зардлаар | Хэвлэлийн бага хурлын тоо, ярилцлагын тоо | 2 | 65 | Тамгын газар | Комиссын цахим хуудаст 84 мэдээ, фэйсбүүкээр 201 пост, твиттерээр 43 удаа жиргэж, байгууллагын онцлох мэдээ мэдээллийг фото зургийн хамт бэлтгэн 3 удаа | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сурталчилах, хэвлэлийн бага хурал зохион байгуулах, ярилцлага өгөх ажлыг хэрэгжүүлэх | | | | | | мэдээллийн самбарт байршуулж Комиссын явуулж буй үйл ажиллагааг сурталчилсан. Тайлант хугацаанд Комиссын зүгээс хэвлэлийн бага хурал зохион байгуулж олон нийтэд мэдээлэл хийгээгүй ч цаг үеийн шинжтэй олны анхаарал татсан асуудлаар Комиссын албан ёсны байр суурийг тус бүр 2 удаа МҮОНРТВ-ийн ММ агентлагийн мэдээллийн хөтөлбөрийн “Онцлох зочин” нэвтрүүлэгт орж мэдээлэл өгсөн.<br>МҮОНРТВ-тэй хамтран ажиллах Санамж бичгийг 2022.04.08-ны өдөр байгуулж хоёр байгууллагын хооронд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж хамтран ажиллаж байна. Тус телевизийн нийгэм эдийн засгийн редакци болон ММ агентлагийн мэдээлллийн хөтөлбөрөөр Комиссын гишүүд дараах сэдвээр мэдээлэл хийсэн. Үүнд:<br>**ХЭҮК-ын дарга Ж.Хунан**:<br>1. Хуулийн засаглал нэвтүүлгээр Комиссын чиг үүрэг хийж буй ажлын талаар;<br>2. Дотуур байранд хүүхдийн эрх зөрчигдөж буй асуудлаар;<br>3. “УИХ ба сэтгүүл зүй” УИХ-ын даргын сэтгүүлчидтэй хийсэн Хүний эрх, эрх чөлөөний асуудлаарх уулзалтаар Комиссоос хийж хэрэгжүүлж буй ажлын талаар;<br>4. Жендэрийн мэдрэмжтэй эрэгтэй удирдагчдыг орон нутгийн түвшинд анх удаа шалгаруулсан асуудлаар;<br>5. МУ дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэлийн хэрэгжилтийн асуудлаар;<br>6. Хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллаган дахь хүний эрх хэлэлцүүлгийн үр дүн, ач холбогдлын талаар;<br>7. Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн асуудлаар;<br>**Комиссын гишүүн Б.Энхболд:** | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 1. “Монголдоо сайхан амьдарья” жагсаалын үеэр Комисс хэрхэн ажилласан болон хүний эрх зөрчигдсөн эсэх асуудлаар;<br>2. 21 дэх илтгэл цэргүүд бэлгийн хүчирхийлэл өртөж буй эсэх асуудлаар тайлбар;<br>3. ММ агентлаг Цагийн хүрд мэдээллийн хөтөлбөрөөр цаг үеийн шинжтэй 5 удаа ярилцлага өгсөн.<br>**Комиссын гишүүн Х.Мөнхзул:**<br>1. ОУ-ын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр “Эмэгтэйчүүдийн эрхийн асуудлын хүрээнд;<br>2. “Дархан бэр” энгэрийн тэмдэг олгох нь хүний эрх зөрчиж буй талаар Цогт цэций сум ИТХ-ын даргад шаардлага хүргүүлсэн асуудлаар;<br>3. Эмэгтэйчүүдийн эрх зөрчигдөж буй асуудал жендэр гэр бүл салалтын асуудлаар болон цаг үеийн шинжтэй мэдээллийг 3 удаа өгсөн.<br>**Комиссын гишүүн Д. Сүнжид:**<br>1. Шинэ үндсэн хууль батлагдсан өдөрт зориулсан хэлэлцүүлэг<br>2. Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн асуудлаар;<br>3. Цаг үеийн шинжтэй ММ агентлагын мэдээллийн хөтөлбөрөөр 8 удаа оролцож ярилцлага мэдээлэл өгсөн.<br>**Комиссын гишүүн Г.Нарантуяа:**<br>1. Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн хүрээнд болон Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудлаар;<br>2. Жагсаал цуглааны үеэр хүний эрх зөрчигдсөн талаар тайлбар тодруулга “Онцлох зочин”-оор болон цаг үеийн шинжтэй мэдээллийг ММ агетлагын мэдээллийн хөтөлбөрөөр 3 удаа өгсөн. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | **ГХШХ-ийн хэлтээс ТВ-ээр 14 удаагийн тодруулга мэдээлэл өгсөн. Үүнд:**<br>1. 2022.01.12-ны өдөр NTV телевизэд хорих ял эдэлж буй өсвөр насны хүний асуудлаар, Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагад хийсэн хяналт шалгалтын талаар<br>2. 2022.01.13-ны өдөр ТВ8 телевизэд Комисст ирүүлсэн гомдол, мэдээллийн талаар<br>3. 2022.01.24-ний өдөр Ийгл телевизэд Хорих 405 дугаар ангид ял эдэлж байхдаа зодуулсан хоригдлын асуудалд Комиссоос авсан арга хэмжээний талаар<br>4. 2022.02.23-ны өдөр ETV-д хүүхдийн эрхийн зөрчил, ялгаварлан гадуурхалтын асуудлаар<br>5. 2022.03.21-ний өдөр С1 телевизэд Завхан аймгийн Тэлмэн сумын цагдаагийн алба хаагч иргэни шонгийн модноос гавласан асуудлаар<br>6. 2022.02.10-ны өдөр 25 дугаар суваг ТВ-д унаач хүүхдийн эрхийн асуудлаар<br>7. 2022.02.10-ны өдөр Монголын радиод унаач хүүхдийн эрхийн асуудлаар<br>8. 2022.02.11-ний өдөр TV8 ТВ-д унаач хүүхдийн эрхийн асуудлаар<br>9. 2022.04.20-ны өдөр ТВ8 телевизийн Толь мэдээллийн хөтөлбөрт Цагдаагийн байгууллагын камержуулалтын талаар<br>10. 2022.04.28-ны өдөр МҮОНТВ-ийн Цагийн хүрд хөтөлбөрт Хөдөлмөрлөх эрхийн талаар<br>11. 2022.05.26-ны өдөр 25 дугаар суваг ТВ-ийн 25 цаг мэдээллийн хөтөлбөрт унаач хүүхдийн эрхийн асуудлаар<br>12. 2022.06.02-ны өдөр ТВ9-ийн Энэ өдөр мэдээллийн хөтөлбөрт иргэн О.Балжиннямын гомдлын талаар | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 13. 2022.06.15-ны өдөр Монголын радиод унаач хүүхдийн эрхийн асуудлаар<br>14. 2022.06.20-ны өдөр TV9, NTV, HD Монгол, Ийгл, Тэнгэр ТВ, үндэсний радиод амь насаа алдсан цэргийн алба хаагчийн талаар тус тус ярилцлага өгсөн. | |
| 6.3.4 | “Хүний эрхийн төлөө” сэтгүүлчдийн клубын үйл ажиллагааг зохион байгуулна | Үйл ажиллагааны зардлаар | Тусгайлан боловсруулсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан уулзалтын тоо | 1 | 6 | ЗУХ | “Хүний эрхийн төлөө” сэтгүүлчдийн клубын гишүүдийг шинэчлэн бүрдүүлсэн бөгөөд энэ хүрээнд харъяалах хэвлэл мэдээллийн байгууллагын ерөнхий редакторуудтай Комиссын гишүүд уулзалт зохион байгуулж, цаашид хамтран ажиллах чиглэлээр санал солилцсон. “Хүний эрхийн төлөө” сэтгүүлчдийн клуб нь 32 сэтгүүлчийн бүрэлдэхүүнтэй бөгөөд байнга мэдээлэл солилцож, Комиссын үйл ажиллагааны талаарх мэдээллээр хангаж ажиллаж байна. Клубын гишүүдийг батлагдсан хөтөлбөрийн дагуу чадавхжуулах сургалтыг сар бүр зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд уг сургалтыг 2022.04.23, 06.04-ны өдөр 2 удаа зохион байгуулсан байна. | 100% |
| **Зорилт 6.4** | | **Хүний эрхийн Үндэсний Комиссын материаллаг болон мэргэжлийн чадавхыг бэхжүүлэх** | | | | | | |
| 6.4.1 | Албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах хөтөлбөрийг шинэчлэн баталж, хэрэгжилтийг хангах; | Үйл ажиллагааны болон төслийн зардлаар | Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн арга хэмжээг үе шаттай авсан байна. | 1 | 100% | ЗУХ | Тамгын газрын даргын 2022.01.05-ны өдрийн А/01 дугаар тушаалаар хоол, унааны хөнгөлөлт шинэчлэн баталж, 02 дугаар тушаалаар төрийн захиргааны албан хаагчдын цалинг 2022.01.05-ны өдрөөс нэмж, 03 дугаар тушаалаар төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 11 албан хаагчид олгосон. Комиссын даргын 2022.02.18-ны өдрийн А/07 дугаар тушаалаар төрийн захиргааны 10 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан, 8 албан хаагчид шинээр зэрэг дэв олгосон. Түүнчлэн 3 албан хаагчид эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулахаар холбогдох материалыг бүрдүүлэн Төрийн албаны зөвлөлд хүргэснээс шаардлага хангасан 1 албан хаагчид эрхэлсэн түшмэлийн гутгаар зэрэг олгосонтой холбогдуулан Тамгын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | даргын 2022.04.25-ны Б/27 дугаар тушаалаар нэмэгдэл олгов.<br>Дотоод журамд заасны дагуу шинэ хүүхэд төрүүлсэн 4, нас барсаны тэтгэмж 2, эмчилгээний зардал 1 албан хаагчид тус тус 500,000 төгрөгийн нийт буцалтгүй тусламж олгосон.<br>Орхон аймаг дахь ахлах мэргэжилтэн Ц.Батзаяа нь албан тушаалын тодорхойлолтод заасан үндсэн чиг үүргийн хүрээнд ажлын байрны осолд орсонтой холбогдуулан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс байгуулах тухай” тушаалыг Тамгын газрын даргын А/09 дүгээр тушаалаар баталж, холбогдох баримт бичгийг бүрдүүлж, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт албан бичгээр хүргүүлсэн. Түүнчлэн орон нутагт томилолтоор ажиллаж байгаа албан хаагчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор “Монгол даатгал” ХХК-тай хамтран гэнэтийн ослын даатгалд хамруулж байна. Эхний хагас жилийн байдлаар нийт 13 албан хаагч хамрагдаад байна.<br>Албан хаагчдын эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх, хамт олны харилцаа, хандлагыг дээшлүүлэх, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс 06 сарын 30-ны өдрийг хүртэл Пүрэв гариг бүрийн 16:00-18:00 цагийн хооронд “Эхлэл” ерөнхий боловсролын сургуулийн спорт заалыг түрээслэн спортоор хичээллэх боломжоор хангасан.<br>Эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж байгаа албан хаагчдыг төрийн дээд болон ХЗДХЯам-ны шагналаар шагнуулахаар Комиссын хуралдаанд танилцуулж, холбогдох баримтыг бүрдүүлэн Ерөнхийлөгчийн Тамгын газар, ХЗДХЯаманд тус тус хүргүүлсэн. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хүний эрхийн салбарт оруулсан хувь нэмрийг үнэлэн Хүчирхийлллийн эсрэг үндэсний төвийн 2, Сонгуулийн ерөнхий хорооны 2 ажилтныг Комиссын нэрэмжит шагналаар шагнасан. | |
| 6.4.2 | Комиссын алба хаагчдын сургалтын төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөний дагуу чадавхыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулах; | Үйл ажиллагааны болон төслийн зардлаар | Мэргэшсэн, чадварлаг хүний нөөц бүрдсэн байна. | 1 | 100% | ЗУХ | **Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалт:**<br>Удирдлагын академийн эрхэлсэн түшмэлийн багц сургалтад 2, ахлах түшмэлийн сургалт 1, төрийн албанд анх орох иргэний чиглүүлэх сургалт 1, давтан сургалтад 2 албан хаагч хамрагдаж төгссөн. Мөн богино хугацааны хүний нөөцийн мэргэшүүлэх сургалтад 1, хөдөлмөрийн харилцааны ойлголт сургалтад 3 албан хаагч тус тус хамрагдсан.<br>**Ажлын байрны дотоод сургалт:**<br>1. Архив, албан хэрэг хөтлөлтийн журмын хэрэгжилтийг хангах тухай сургалт- 36 албан хаагч,<br>2. Компьютерийн мэдлэг, ур чадвар дээшлүүлэх сургалт - 28 албан хаагч,<br>3. Шинээр томилогдсон албан хаагчдад хүний эрх хамгаалах чиглэлээр онолын болон хууль, эрх зүйн мэдлэг олгох, захиргааны дотоод үйл ажиллагааны зохион байгуулалтын талаар мэдээлэл өгөх 3 цагийн сургалт - 26 албан хаагч,<br>4. “Байгууллагын соёл” сэдэвт сургалтад 21 албан хаагч,<br>5. НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба болон БНСУ-ын Статистикийн төвийн хамтарсан Ази, Номхон далайн орнуудын Гэмт хэрэг, эрүүгийн эрх зүйн байдлын статистикийн мэргэжлийн төв (CoE), НҮБ-ын Ази, Номхон Далайн Статистикийн Хүрээлэн (SIAP)-ээс “Гэмт хэргийн статистикийг жендэрийн үүднээс судлах хоёр дахь удаагийн цахим сургалт”-д 3 албан хаагч,<br>6. Монголын Эмнести интернэшнлтэй хамтарсан Жагсаал цуглааны үеэр хүний эрхийн ажиглагчийн хэрэгжүүлэх үйл | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллагаа, хариуцах эрх үүргийн талаар онолын болон хууль эрх зүйн мэдлэг олгох 2 өдрийн сургалт зохион байгуулж, Тамгын газраас 12 албан хаагч хамрагдсан.<br>**Бусад байгууллагаас зохион байгуулсан сургалт:**<br>1. Сангийн яамнаас зохион байгуулсан төсвийн бодлого төлөвлөлтийн талаарх танхимын 2 өдрийн сургалтад 1 албан хаагч,<br>2. УИХ-ын хяналт шалгалтын тухай хууль, уулзалт хэлэлцүүлэгт 2 албан хаагч,<br>3. “Стратегийн өмгөөлөл, сүүдэр илтгэл бичих арга зүй” сэдэвт сургалтад 1 албан хаагч хамрагдсан. | |
| 6.4.3 | Байгууллагын дэргэдэх зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах; | Үйл ажиллагааны зардлаар | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар | 0 | 100% | Тамгын газар | Байгууллагын дэргэдэх зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нийт албан хаагчдаас санал авч байгуулсан. Үүнд:<br>- ТГ-ын даргын 2022.05.12-ны өдрийн А/29 дүгээр тушаалаар “Байгууллагын дэргэдэх Ёс зүйн зөвлөл”;<br>- ТГ-ын даргын 2022.05.12-ны өдрийн А/12 дугаар тушаалаар “Соёл, спорт, олон нийтийн зөвлөл”;<br>- ТГ-ын даргын 2022 оны А/09 дүгээр тушаалаар "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс". | 100% |
| 6.4.4 | Санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг хангаж, тайлагнах; | Үйл ажиллагааны зардлаар | Санхүүгийн төлөвлөлт, тайлагналтын чанар, тоо | 1 | 12 | ЗУХ | - Комиссын 2021 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн яамны Төрийн сангийн газарт 2022.04.25-нд албан бичгийн хамт хүргүүлсэн.<br>- 2021 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд аудитын шалгалт хийгдэж, “Зөрчилгүй дүгнэлт” авсан.<br>- Сар бүрийн санхүүгийн гүйцэтгэлийн мэдээг хуулийн хугацаанд Сангийн яамны холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн.<br>- Комиссын 2023 оны төсвийн төслийн тооцооллыг хийж албан бичгийн хамт 06 дугаар сарын 10-нд Сангийн яаманд, 06 | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дугаар сарын 15-ны өдөр УИХ-ын дарга Д.Занданшатарт тус тус явуулсан. | |
| 6.4.5 | Санхүүгийн үйл ажиллагааг хөтлөн зохион байгуулах, эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг хангах; | Үйл ажиллагааны зардлаар | Санхүүгийн үйл ажиллагаа, эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж ажилласан байна. | 1 | 1 | ЗУХ | 2022.02.28-ны өдөр батлагдсан хөрөнгө оруулалтын дагуу “Авто машин”, “Тавилга, эд хогшил”, “Тоног төхөөрөмж” худалдан авах тендер зарласан. Үүнээс авто машин худалдан авах тендер хүчингүй болсон ба тоног төхөөрөмж нийлүүлэх ажилд “Би Си Ти” ХХК 103,252,840 төгрөгийн 16 нэр төрлийн 75 ширхэг бараа нийлүүлэх гэрээ байгуулсан. Тавилга эд хогшил нийлүүлэх ажилд “Хашхан” ХХК 38,430,000 төгрөгийн 10 нэр төрлийн 67 ширхэг бараа нийлүүлэх гэрээ байгуулсан.<br>“Би Си Ти” ХХК 2022.05.17-ны өдөр 12 нэр төрлийн 43 ширхэг барааг хүлээлгэн өгсөн. Үүнд: Принтер 6ш, Цаас устгагч 4ш, Суурин утас 7, Зөөврийн компьютер 7ш, Хувилагч /Том оврийн/ 2ш, Видео камер жижиг 1ш, Дуу хураагуур 5ш, Сканнер 1ш, Wifi цацагч 4ш, Гэрэлтүүлэг хэмжигч 2ш, Лазер талбай хэмжигч 2ш, Электрон чийг дулаан хэмжигч 2ш.<br>“Би Си Ти” ХХК, “Хашхан” ХХК-ууд хил гаалийн нөхцөл байдлын улмаас гэрээний хугацааг 60 хоногоор сунгах хүсэлт ирүүлсэний дагуу хугацааг 2022.07.19-ны өдрийг хүртэл сунгасан. | 30% |
| 6.4.6 | Үйл ажиллагааны зардлаар, санхүүгийн ил тод байдал, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, тайлагнах; | Үйл ажиллагааны зардлаар | Мэдээллийг хугацаанд нь тухай бүр цахим санд мэдээлсэн байна | 1 | 12 | ЗУХ | Байгууллагын Шилэн дансанд төсөв, санхүүгийн ил тод байдал, төсвийн байгууллагын төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 10 мэдэгдлийг сар бүр хугацаанд нь оруулсан. Мөн хүний нөөцийн ил тод байдлыг хангаж, сар бүр Тамгын газрын бүтэц орон тооны мэдээлэл болон ашиг сонирхлын зөрчил үүсээгүй тухай 20 мэдэгдэл тайлбарыг оруулсан. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, төсвийн хэтрэлт хэмнэлтийн тооцоог хийж, хэмнэлт хийгдэх ангиллаас төсвийн хуваарьт санхүүжилтгүй ангилал руу | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Сангийн яамнаас зөвшөөрөл авч шилжүүлэн зарцуулсан. | |
| Нэмэлт | Орон нутгийн ажилтнуудын цугларалт, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах | Улсын төсөв, төсөл | Мэргэшсэн, чадварлаг хүний нөөц бүрдсэн байна. | 2 | 2 | 2, 4 | Орон нутгийн ажилтнуудын сургалт, цугларалтыг 07 дугаар сарын 04-08-ны өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөж, санхүүгийн тооцоо, сургалтын хөтөлбөр боловсруулж, бэлтгл ажлыг хангаж ажиллаж байна. | 70% |
| **Зорилт 6.5** | | **Хүний эрхийн комиссын үйл ажиллагааг цахим шилжилтийн бодлогод нийцүүлэн хөгжүүлэх** | | | | | | |
| 6.5.1 | Хүний эрх аппликэйшныг шинэчлэн хөгжүүлэх; | Үйл ажиллагааны болон төслийн зардлаар | Хөгжүүлэлтийн ажил хийгдсэн байна. | 20% | 100% | ХЭБСХ | "Хүний эрх" аппликэйшн хийх ажлын даалгаврыг боловсруулж, холбогдох нэгжүүдээс болон ЦХХХЯ-ны Бодлого зохицуулалтын газрын дарга н.Билэгдэмбэрэлтэй уулзаж санал авсан. Санал авсан хувилбар болон шаардагдах төсвийн талаар Комиссын хуралд танилцуулсан бөгөөд хурлаас "Хүний эрх" апп-ыг 2023 онд хөгжүүлэхээр хойшлуулсан. Мөн н.Соёл-Эрдэнэ (Легалдатаг хөгжүүлэгч)-тэй холбогдож, "Хүний эрх" аппликэйшны ажлын даалгаврыг сайжруулахад дэмжлэг хүсэж хандсан бөгөөд түүнтэй 2022.06.10-нд Комиссын гишүүд, холбогдох албан хаагч уулзаж, зөвлөгөө мэдээлэл авч, санал солилцсон. | 30% |
| 6.5.2 | Хүний эрхийн цахим номын сангийн хөгжүүлэлтийг эхлүүлэх; | Үйл ажиллагааны зардлаар | Хүний эрхийн цахим номын санд хандах хэрэглэгчийн тоо нэмэгдсэн байна. | 50% | 100% | ЗУХ | Цахим номын сангийн хандах эрхийн тохиргоог шинээр хийлгэхээр гүйцэтгэгч “Волвес” ХХК-д албан бичиг хүргүүлсэн.<br>Тайлант хугацаанд Комиссын цахим номын санд 12 баримтыг оруулж, баяжилт хийсэн. Үүнд:<br>- Монгол Улс дахь Хүний эрх, Эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэл<br>- Жендэр судлал Эрдэм шинжилгээний сэтгүүл 2021 №4<br>- Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй холбоотой гомдлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд | 30% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хянан шийдвэрлэх талаарх аргазүйн зөвлөмж<br>- Хүн бүрт хүртээмжтэй Монголыг бүтээх түүхүүд UNTOLD<br>- Хүүхдийн эрхийн стандартын эмхэтгэл<br>- Хуульч бэлтгэх гадаад орнуудын туршлага<br>- Парламент судалгааны эмхэтгэл боть 36<br>- Парламент судалгааны эмхэтгэл боть 37<br>- Парламент судалгааны эмхэтгэл боть 38<br>- Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит, 2022 оны ээлжит бус чуулганы үйл ажиллагааны болон хүндэтгэлийн хуралдааны танилцуулга<br>- “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал” судалгааны тайлан<br>- Шүүх эрх мэдэл мэдээлэл, арга зүйн улирал тутмын эмхэтгэл 2021 №4 | |
| 6.5.3 | Байгууллагын мэдээллийн технологийн төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах; | Үйл ажиллагааны зардлаар | Мэдээллийн технологийн засвар үйлчилгээг тогтмол хийх, хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан байна. | 0 | 100% | ЗУХ | Комиссын мэдээллийн технологийн төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.Үүнд:<br>- 12 албан хаагчийн MS-Office лицензийн хугацааг сэргээсэн.<br>- 3 компьютерт SPSS судалгааны программыг суулгасан.<br>- ХЭБСХ, ОУГЭЗХАХ, ГХШХ-ын принтерийн доголдолыг арилгасан. (18 удаагийн давтамжтай)<br>- Шинээр ажилд орсон 2 албан хаагчид хуучин компьютер форматалж хүлээлгэн өгсөн.<br>- Принтер драйвер CD-ээр суулгах ажиллагаа 20 удаа хийсэн.<br>- Сүлжээний IP хаяг унасан 6 албан хаагчийн IP сэргээсэн.<br>- Цаг бүртгэлийн төхөөрөмж сүлжээнд холбож Able системтэй холбосон. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - nhrcm.gov.mn цахим хуудасны зарим засвар, үйлчилгээ болон мэдээ тайлан оруулах, илтгэлийн хувилбар оруулах ажлуудыг хийсэн.<br>- live төхөөрөмж болон дүрс бичлэгийн камерын хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.<br>- Интернетийн хэвийн ажиллагаа, Комиссын гишүүд, албан хаагчдад мэдээлэл технологийн туслалцаа дэмжлэгийг өдөр бүр үзүүлэн ажиллаж байна. | |
| **ХОЁР: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛААР ХАНГАХ** | | | | | | | | |
| 2.1 | Дэмжих бүлэг болон хүний эрхийн сургалтаар туслах малчдыг чадавхжуулах | Европын холбооны санхүүжилтээр | Төслийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна. | 50% | 100% | ХЭБСХ, Ажлын хэсэг | Туслах малчдад зориулсан комик ном хэлбэрийн гарын авлагын сэдэв, агуулга, бүтэц, зохиолын талаар зураач, зохиолч Д.Төрмөнхтэй тохиролцож, ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. Мөн туслах малчдад зориулсан 8 гарын авлагын зохиолд саналаа тусгаж, комик номын эхний хувилбар болон төслийн үнэлгээг хийх ажлын гэрээний төслийг хянаж, төслийн гүйцэтгэлийн тайланг боловсруулсан.<br>“Туслах малчдын нийгэм, эдийн засгийн байдал хүний эрхийн хэрэгжилт” судалгааны тайланг товхимол болгон 500 хувь хэвлүүлсэн. | 70% |
| 2.2 | “Нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрх” судалгаа, сургалт:<br>- Их, дээд сургуулийн орчин дахь багш, оюутнуудын бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн хэрэгжилт, өнөөгийн байдалд хяналт, үнэлгээ хийх, сургалт зохион байгуулах | НҮБХАС-ийн санхүүжилтээр | Төслийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна. | 20% | 100% | ХЭБСХ | “Их дээд сургуулийн оюутан залуусын бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн хэрэгжилт” судалгааны удирдамжийг 2022.05.20-ны өдөр Комиссын гишүүн Х.Мөнхзулаар батлуулан, гишүүний өгсөн чиглэлийн дагуу ажлын даалгавар, асуумжийг боловсруулан ажилласан. Судалгааны зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах зарын дагуу нийт 3 байгууллага материалаа ирүүлснээс “Цаглашгүй мэдлэг” НҮТББ-ыг сонгон хамтран ажиллаж байна. Судалгааны ажлын хүрээнд 2022.05.29-2022.06.11-ний өдрүүдэд Ховд, Завхан Дархан-Уул, Орхон аймагт томилолтоор ажилласан ба томилолтын | 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | илтгэх хуудас, Комиссын гишүүний шаардлага боловсруулж байна.<br>Мөн 2022 онд ХЭҮК-ын ажилтнуудад сургалт зохион байгуулахаар төлөвлөж, Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Ази номхон далайн бүсийн чуулганы жендэрийн багийн мэргэжилтэн Фасо Айшат руу албан захидал илгээж улмаар цахим уулзалтыг 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулсан. Уг уулзалтаар “ХЭҮБ үйл ажиллагаандаа нөхөн үржихүйн эрхийг интеграцчилах нь” сургалтыг Комиссын ажилтнуудад зохион байгуулах талаар санал солилцон улмаар 10 дугаар сард хийхээр харилцан тохирсон. | |
| 2.3 | Монгол Улс дахь хоригдлын хөдөлмөрийн нөхцөл байдлын судалгаа | ОУХБ санхүүжилтээр | Төслийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна. | 20% | 100% | Ажлын хэсэг | “Хоригдлын ажил, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал”-ын судалгааны удирдамж, ярилцлагын анкет, ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагыг хянаж, судалгааны тайланд санал өгсөн.<br>Ажлын хэсгийн гишүүд Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагаас 2022.02.14-ний өдөр зохион байгуулсан уулзалтад оролцож, 2022.02.15-ны өдөр зохион байгуулсан сургалтад хамрагдсан. | 50% |
| 2.4 | Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх | НҮБХХ-ийн<br><br>анхүүжилтээр | Төслийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна. | 20% | 100% | ХЭБСХ, ГХШХ | Дорноговь аймгийн Айраг, Даланжаргалан сум, Төв аймгийн Баянжаргалан сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын үйл ажиллагаанд ХЭНБҮ хийсэн судлаачийн тайлантантай танилцаж, тайланд тусгуулах саналыг боловсруулж НҮБ-ын Байгаль орчны мониторингийн төслийн менежерт хүргүүлсэн. | 50% |
| 2.5 | "Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь" төслийг төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх | КОИКА ОУБ, НҮБХХ-ийн санхүүжилтээр | Төслийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна. | 20% | 100% | ХЭБСХ | "Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь" төслийн хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүллээ. Үүнд:<br>- 2022.02.06-наас 13-ны өдрүүдэд Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай аймгуудын Засаг даргын Тамгын газарт Жендэрийн эрх тэгш байдлыг хангах | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, Комиссын гишүүний зөвлөмжийг хүргүүлсэн.<br>- Монголын эмэгтэйчүүдийн холбоотой хамтран “2020 оны ээлжит сонгуульд нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн сонгох, сонгогдох эрхийн зөрчил түүний шалтгаан нөхцөлийг тогтоох судалгаа”-ны ажлыг 2022.01.25-ны өдрөөс эхлүүлж, улсын хэмжээнд 631 сонгуульд нэр дэвшсэн эмэгтэйчүүдээс судалгаа авч, судалгааны тайланд 2 удаа санал өгсөн.<br>- "Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь" төслийн хүрээнд зохион байгуулсан "Зан үйлийн аргачлалыг ашиглах нь" цахим сургалтад Комиссын асуудал хариуцсан албан хаагч 2022.02.25-ны өдөр хамрагдсан.<br>- НҮБ-ын хөгжлийн Хөтөлбөрийн “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төсөл, БНСУ-ын Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-тай хамтран жендэрийн мэдрэмжтэй эрэгтэй удирдагчдыг шалгаруулах ажлыг 2022.02.21-ний өдрөөс эхлүүлсэн. Уг арга хэмжээнд 19 аймгийн 170 гаруй байгууллагын 1800 гаруй албан хаагч хамрагдаж, аймаг бүрт гурван салбараар жендэрийн мэдрэмжтэй 29 удирдагчдаас орон нутгийн хэмжээнд 5 шилдэгийг шалгаруулж Комиссын гишүүд шагналыг Монгол цэргийн өдөр, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 101 жилийн ойн баярын өдөр буюу 2022.03.18-нд гардуулсан. Үүнд:<br>Жендэрийн мэдрэмжтэй шилдэг удирдагчаар төрийн байгууллагаас: | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | ○ Архангай аймгийн Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газрын дарга Ч.Батнайрамдал нь ажлын байранд хүүхэд хөхүүлэх, тоглох, хичээл давтах тусгай өрөөг тохижуулан албан хаагчдынхаа тав тухтай ажиллах орчинг бүрдүүлсэн үзүүлэлтээр;<br>○ Увс аймгийн Хөдөлмөр халамж,үйлчилгээний газрын дарга Д.Цогт-Очир эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, гэр бүл, залуучуудын зөвлөл байгуулан тэдний оролцоо, манлайлал, хамтын ажиллагааг дэмжиж ажиллахын зэрэгцээ албан хаагчдын хүүхдүүд болон төрийн үйлчилгээ авахаар ирсэн иргэдийн хүүхдүүдэд зориулан саатуулах өрөөг тохижуулсан амжилтаар;<br>○ Дархан-Уул аймгийн Дархан сумын засаг дарга Т.Тулгаа Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулахаар “Хамтарсан баг”-ийн үйл ажиллагааг дэмжих зардлыг нэмэгдүүлж, 18 хамтарсан багтай хамтарч сургалт, нөлөөллийн ажлыг сумдад зохион байгуулсаны зэрэгцээ Дархан суманд “Сэтгэл зүйн” 5 төвийг шинээр нээхээр судалгаа хийж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж буй үзүүлэлтээр;<br>○ “Ус-Ду” ОНӨААТҮГ-ын захирал Б.Ганзориг нь ажлын байран дахь жендэрийн эрх тэгш байдлын талаар санал солилцох уулзалтыг тогтмол зохион байгуулан үр дүнг хэлэлцэхийн зэрэгцээ ажлын байран дахь бүх хэлбэрийн дарамт, ажилчдын ёс зүй, харилцаа хандлагын талаарх сургалтад ажилтнуудаа тогтмол хамруулдаг; | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Жендэрийн мэдрэмжтэй шилдэг удирдагчаар хэвлэл мэдээллийн байгууллагаас:<br>○ Орхон аймгийн “Номин” телевизийн захирал Х.Хишигбаатар нь байгууллагын нийт ажилчдын ажиллах орчин нөхцөл, техник хэрэгслийг сайжуулж, ажилчдын цалин, урамшуулал, нийгмийн хангамжийн хувьд хүйсээр ялгаварлан гадуурхахгүйгээр адил тэнцвэртэйгээр олгодог. Телевизийн эфирээр гаргаж буй нэвтрүүлэг, контентын агуулга нь жендэрийн тэгш бус байдал, аль нэг хүйсийг ялгаварлан гадуурхсан, эрхийг зөрчсөн мэдээ мэдээлэл нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, нөлөөллийн ажлаараа тус тус шалгарсан.<br>- 2022.02.25-ны өдөр “Жендэрийн эрх тэгш байдал ба хүний эрх” хэлэлцүүлгийг зохион байгуулж жендэр, жендэрийн эрх тэгш байдлын чиглэлээр ажилладаг 20 гаруй байгууллагын эрх бүхий албан тушаалтан, экспертүүдэд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт, Комиссоос зохион байгуулсан хяналт шалгалтын дүн, “Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн чанарын судалгааны явцыг тус тус танилцуулсан. | |
| 2.6 | “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийг хэрэгжүүлэхэд оролцох | НҮБХХ-ийн санхүүжилтээр | Төслийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна. | 20% | 100% | Ажлын хэсэг | 1. “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн хүрээнд сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга нар, төрийн тусгай, захиргаа, үйлчилгээний албан хаагчидад зориулсан “Жендэр ба хүний эрх” сургалтын 7 сэдвийн агуулга, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, танилцуулга бэлтгэж Сэлэнгэ, Говь-Алтай, Баян-Өлгий, Завхан, Увс, Төв аймагт сургалт зохион байгуулсан.<br>2. “Хүний эрхийн мэдрэмжтэй төрийн алба”, “Хөдөлмөрийн хүрээний дарамт, хүчирхийлэл хүний эрхийн зөрчил болох” сэдвийн хүрээнд | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалтын гарын авлага, бүсчилсэн хэлэлцүүлэг уулзалтын хөтөлбөрийг боловсруулсан.<br>3. "Төрийн тусгай албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт", "Төрийн үйлчилгээний албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт" судалгааны ажилд оролцохоор 3 байгууллага материалаа ирүүлснийг 2022.06.17-ны өдөр хүсэлт ирүүлсэн байгууллагын төлөөлөл болох судлаач, хуульчидтай уулзалт зохион байгуулж “Хөгжлийн санаачилга, бодлого судлалын төв” ТББ, Хууль зүйн үндэсний хүрээлэнгээр хийлгэхээр сонгосон. | |
| 2.7 | “Хүний эрхийн үндэсний комиссын чадавхийг бэхжүүлэх” бичил төсөл хэрэгжүүлэх | Нээлттэй нийгэм форум санхүүжилт | Төслийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна. | 20% | 100% | ОУГЭЗХАХ, ЗУХ | Нээлттэй нийгэм форумын дэмжлэгээр “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссыг эрх зүйн шинэтгэлийн шилжилтийн үед дэмжих нь“ төслийг 2021 оны 11 дүгээр сараас хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд төслийн 1 дүгээр шат Комиссын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах чадавхийг бэхжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулах хүрээнд иргэд, салбарын мэргэжилтнүүд, хамтрагч байгууллагуудтай хүний эрхийн тодорхой сэдвээр уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах үйл ажиллагааны хүрээнд хэрэгжиж дууссан бөгөөд үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг ННФ-д илгээсэн. Төслийн 2 дахь шатны хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг илгээж, хэрэгжүүлж эхлээд байна. | 70% |
| **ГУРАВ: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛААР ХАНГАХ** | | | | | | | | |
| 3.1 | Комиссын хуралдаан, гишүүдийн хурал, уулзалт, Тамгын газрын хурлын үйл ажиллагааны бэлтгэл зохион байгуулалтыг хангах, тэмдэглэл хөтлөх, шийдвэрийн | Үйл ажиллагааны зардлаар | Шийдвэрийг нь баталгаажуулж, тэмдэглэл бичсэн хурлын тоо | 12 | 12 | ЗУХ | Тайлант хугацаанд Комиссын хурал, Тамгын газрын хурлыг тус бүр 6 удаа зохион байгуулж, хэлэлцсэн асуудлын шийдвэрийг баталгаажуулж ажилласан. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг хангаж, тайлагнах | | | | | | | |
| 3.2 | Байгууллагын стратеги төлөвлөгөө (2021-2026 он)-ний хэрэгжилтийг хангаж, тайлагнах | Үйл ажиллагааны зардлаар | Хууль, журамд нийцүүлэн боловсруулж батлуулсан стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг үе шаттайгаар хангасан байх | 0 | Тийм | Тамгын газар | Стратеги төлөвлөгөөг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган биелэлтийг хангаж ажиллаж байна. | 100% |
| 3.3 | Байгууллага, нэгжийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангуулж, тайлагнах | Үйл ажиллагааны зардлаар | Гүйцэтгэлийн төлөвлөгөө, үнэлгээний тайланг нэгж, ажилтнуудаас авч хугацаанд нь цахим хуудаст байршуулсан байна | 0 | 5 | ЗУХ | Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Комиссын дарга, гишүүд болон хэлтсийн дарга нарын саналыг тусган Комиссын хуралдаанаар хэлэлцэж, 2022.01.10-ны өдөр баталж, хэлтсүүд байгууллагын төлөвлөгөөнд уялдуулж хэлтсийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Хэлтсүүд гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сар бүр Комиссын хуралдаанд тайлагнаж ажилласан. | 100% |
| 3.4 | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, гүйцэтгэлийг тогтоосон хугацаанд гаргаж холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж тайланг хугацаанд нь гаргасан байна | 0 | Тийм | Тамгын газар ЗУХ | Нийт албан хаагчид төрийн албан хаагчийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Комиссын болон хэлтсийн төлөвлөгөөнд үндэслэн боловсруулж батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг сар бүр тайлагнаж ажилласан бөгөөд Тамгын газрын даргын 2022.06.15-ны өдрийн А/46 дугаар тушаалаар эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн үнэлэх Үнэлгээний баг байгуулагдаж 2022.06.24-ний дотор багтаан дүгнэхээр ажиллаж байна. | 90% |
| 3.5 | Байгууллагын албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаа заавар, журмын дагуу хэвийн явуулах | Үйл ажиллагааны зардлаар | Албан хэрэг хөтлөлт, архивын ажлыг заавар, журмыг дагуу хэвийн явуулж, тайлагнаж, | 78,5 % | 100% | Тамгын газар | 1. 2021 онд үүсч хөтлөгдсөн нийт 239 хадгаламжийн нэгж (ХН)-ийг байгууллагын архивт хүлээн авч үдэж хавтаслан байнга хадгалах 52 хадгаламжийн нэгжийн 7129 хуудсыг дугаарласан.<br>Комиссын 2001-2021 оны захирамжлалын 53 ХН-ийн 3435 хуудас баримтыг цахимжуулж, | 30% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | архивласан байна | | | | архивын өрөө тасалгааг цэвэрлэж 2001-2003 оны 4119 хуудас баримтыг нягтлан шалгаж хадгалах хугацаа дууссан, илүү хувь баримтыг ялгаж устгах баримтын жагсаалтад бүртгэсэн. Тайлант хугацаанд нийт 34 баримт бичгийн 177 хуудас материалд “Хуулбар үнэн” тэмдгээр баталгаажуулж, дотоодын хэрэгцээнд нийт 126 хадгаламжийн нэгж, 4 ном ашиглуулж бүртгэл хөтөлж ажилласан.<br>2022 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж Баримт бичиг нягтлан шалгах комиссын ээлжит хурлаар хэлэлцүүлж батлуулахад бэлтгэсэн.<br>2. Тайлант хугацаанд Комисст хандсан 516 албан бичиг, 439 өргөдөл, гомдол бүртгэж, нийт 640 албан бичиг, Комиссын зөвлөмж 2, Гишүүний зөвлөмж 20, Гишүүний шаардлага 16-ааг тус тус хэвлэмэл хуудаст буулгаж албажуулан, холбогдох газруудад хүргүүлсэн.<br>Албан хэрэг хөтлөлтийн тайлан мэдээг (нийт ирсэн, явсан бичиг, өргөдөл гомдол тэдгээрийн шийдвэрлэлтийн дэлгэрэнгүй тайлан, мэдээ) сар тутам, хэвлэмэл хуудасны захиалга, зарцуулалтын мэдээг хагас жилээр гаргаж удирдлагад танилцуулсан.<br>Улсын Их хурал, Засгийн газраас шигээр баталсан 21 тогтоол, 29 хуулийг бүртгэж байгууллагын албан хэрэг хөтлөлтийн систем (able)-д тухай бүр нийтэлж, нийт албан хаагчдад танилцуулсан.<br>3. Комиссын даргын А тушаал 3 гарсан (Ажлын хэсэг байгуулах тухай 2, шагналд тодорхойлох тухай 1).<br>Тамгын даргын А тушаал нийт 47 гарсан (Томилолтоор ажиллуулах тухай 28, гэрээ байгуулах эрх олгох тухай 2, хоол унааны хөнгөлөлт олгох 1, цалин шинэчлэн тогтоох 1, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох 1, ажлын хэсэг, зөвлөл байгуулах тухай 4, бусад зохион байгуулалтын шинжтэй 10). | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Тамгын даргын Б тушаал 38 гарсан (Буцалтгүй тусламж олгох 10, цалингүй чөлөө олгох 1, зэрэг дэвийн нэмэгдэл олгох 1, цалингийн шатлал ахиулах 1, ажлаас чөлөөлөх 2, жирэмсний амралт олгох 1, байгууллага дотроо албан тушаал шилжүүлэн томилох 1, өөр байгууллагаас шилжүүлэн томилох 7, төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх 2, сургалтад хамруулах 2, бусад 10). Тайлант хугацаанд гарсан бүх тушаалыг Эбле цахим системд бүртгэж оруулсан. | |
| 3.6 | “Төрийн албан хаагчийн ёс зүй, авлига, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, хяналт тавьж, тайлагнах | Үйл ажиллагааны зардлаар | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар | 100% | 100% | ЗУХ | 1. 2021 оны Хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргасан 36 албан хаагчид арга зүйн заавар, зөвлөгөө өгч, хуулийн хугацаанд багтаан мэдүүлгээ гаргаж баталгаажуулах ажлыг зохион байгуулсан. Мөн 2021 оны тайланг ХАСХОМ-1, ХАСХОМ-2 маягтаар гаргаж, гэрээ байгуулах асуудлаар гаргасан ашиг сонирхлын зөрчил үүсээгүй тухай 20 мэдэгдэл тайлбарыг meduuleg.iaac.mn цахим системд бүртгэсэн.<br>Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 5 албан хаагчийн урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраар хянуулж, ирүүлсэн хариуг үндэслэн 5 иргэнийг ажилд томилсон. Шинээр томилогдсон ХЭҮК-ийн 2 гишүүнийг томилох тухай УИХ-ын тогтоол болон хувийн мэдээллийг АТГ-ын хариуцсан ажилтанд хүргүүлж, хуулийн хугацаанд багтаан хөрөнгө оруулгын мэдүүлгийг бөглөх талаар заавар зөвлөмж өгч ажилласан.<br>2. Эхний хагас жилийн байдлаар нийтийг хамарсан 9 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 82 ажилтан илүү цагаар болон амралтын өдрүүдэд ажилласан ба албан хаагчдын ажлын цаг ашиглалт, сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр тогтмол хяналт тавьж, ажлын цаг ашиглалтын тайланг Комиссын хуралдаанд сар бүрийн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | танилцуулсан. Тайлант хугацаанд өвчтэй 14, чөлөөтэй 16, давхардсан тоогоор 67 албан хаагч томилолтоор ажилласан байна. | |
| 3.7 | Комиссын гишүүдэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | Үйл ажиллагааны зардлаар | Үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажилласан эсэх | 0 | Тийм | Тамгын газар | Энэхүү ажлын хүрээнд дарга, гишүүдийн туслахууд тэдний оролцсон уулзалт, хэлэлцүүлгийн бэлтгэл ажлыг хангаж, техникийн туслалцаа үзүүлж ажилласан байна. Үүнд:<br>- Комиссын дарга Ж.Хунан 30 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг;<br>- Комиссын гишүүн Б.Энхболд, Х.Мөнхзул нар 71 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг;<br>- Комиссын гишүүн Д.Сүнжид 15 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг;<br>- Комиссын гишүүн Г.Нарантуяа 13 удаагийн уулзалт хэлэлцүүлэгт тус тус оролцсон байна.<br>Мөн тухай бүр гишүүд болон Тамгын газрын даргаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажилласан. | 100% |
| 3.8 | Байгууллагын үйл ажиллагааны хяналт шинжилгээ, үнэлгээг төлөвлөж, хэрэгжилтийг хангуулж, тайлагнах | Үйл ажиллагааны зардлаар | Батлагдсан төлөвлөгөөний дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. | 0 | 100% | ЗУХ | Комиссын 2022 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөгөө болон үйл ажиллагаанд хамаарах бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэр, бусад баримт бичгийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ үнэлгээ хийх календарчилсан төлөвлөгөөг батласан.<br>Тайлант хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>- Комиссын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан,<br>- Комиссын шилэн данс, санхүүгийн үйл ажиллагаа,<br>- Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зөвлөмж дүгнэлтийг Тамгын газрын даргад танилцуулсан.<br>Комисст хамаарал бүхий 31 хуулийн 233 зүйл заалт, УИХ-ын тогтоол, ЗГ-ын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, ЗГ-ын хуралдааны | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тэмдэглэл болон Комиссын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй 25 дүрэм журам, хөтөлбөрийн жагсаалтыг гаргаж, хяналтад авсан. | |
| | **Нийт** | | | | | | **64.5 оноо** | |